



**САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ**  
**БИЗНЕСИЙН ЭРХ ЗҮЙН МАГИСТРЫН ХӨТӨЛБӨР**

**Дайртан**

**Цогтгэрэлийн ГЭРЭЛМАА**

**Багшийнхан**

**Бадрахын НОМИН-ЭРДЭНЭ**

**Цагаагчууд**

**Батцэнгэлийн МӨНХБАТ**

**Авгас**

**Батдэлгэрийн ӨЛЗИЙТОГТОХ**

**НҮҮРСНИЙ ЭКСПОРТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ**  
**СУДАЛГАА**



**Мэргэжлийн индекс**

**E04880201**

**Бизнесийн эрх зүйн магистрын зэрэг горилсон**  
**судалгааны ажил**

**Удирдсан**

**Ж.Оюунтунгалаг /LL.D./**

**Улаанбаатар. 2023**



**САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ  
БИЗНЕСИЙН ЭРХ ЗҮЙН МАГИСТРЫН ХӨТӨЛБӨР**

**Дайртан**

**Цогтгэрэлийн ГЭРЭЛМАА**

**Багшийнхан**

**Бадрахын НОМИН-ЭРДЭНЭ**

**Цагаагчууд**

**Батцэнгэлийн МӨНХБАТ**

**Авгас**

**Батдэлгэрийн ӨЛЗИЙТОГТОХ**

**НҮҮРСНИЙ ЭКСПОРТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ  
СУДАЛГАА**

**/Research on legal framework of coal export/**



Мэргэжлийн индекс

E04880201

**Бизнесийн эрх зүйн магистрын зэрэг горилсон  
судалгааны ажил**

Удирдагч: ..... Ж.Оюунтунгалаг /LL.D./

Зөвлөх: ..... З.Шагдарсүрэн /LLM/

Зөвлөх: ..... М.Халиун /PhD/

Улаанбаатар. 2023

## **ГАРЧГИЙН ТОВЬЁОГ**

МЭДЭГДЭХ ХУУДАС .....	i
ТАЛАРХАЛ.....	ii
ТОВЧ ХУРААНГУЙ.....	iii
ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ .....	iv
ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ .....	v
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ .....	vi
УДИРТГАЛ.....	1
I БҮЛЭГ ОНОЛЫН ХЭСЭГ .....	3
1.1 Нүүрсний ерөнхий ойлголт .....	3
1.2 Монгол Улсын гадаад худалдааны эрх орчин, бодлогын баримт бичгүүд .....	6
1.3 Судлагдсан байдлын судалгаа.....	7
II БҮЛЭГ СУДАЛГААНЫ ХЭСЭГ .....	15
2.1 Өнөөгийн нөхцөл байдал .....	15
2.2 Гадаад худалдаа, экспорт.....	19
2.3 Нүүрсний салбарын экспортын эрх зүйн орчин.....	29
2.4 Гадаадын зарим орны нүүрсний экспорттой холбоотой эрх зүйн орчин .....	36
ДҮГНЭЛТ.....	48
НОМ ЗҮЙ .....	i

## НҮҮРСНИЙ ЭКСПОРТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ СУДАЛГАА

### МЭДЭГДЭХ ХУУДАС

Энэхүү судалгааны ажил нь миний өөрийн бүтээл болохыг баталж байна. Энэхүү бүтээл нь СЭЗИС-ийн оюуны өмч болох бөгөөд тус сургуулийн номын сан судалгааны ажлыг нийтийн хүртээл болгохыг зөвшөөрч байна.

Магистрантын нэр: Б.Мөнхбат

Гарын үсэг:

Б.Номин-Эрдэнэ

Б.Өлзийтогтох

Ц.Гэрэлмаа

## **ТАЛАРХАЛ**

Бидний судалгааны ажлыг хийж гүйцэтгэхэд туслалцаа үзүүлсэн судалгааны удирдагч багш Ж.Оюунтунгалаг Доктор (LL.D.) СЭЗИС-ийн дэд профессор, зөвлөх багш З.Шагдарсүрэн, Магистр (LL.M Tokyo University, LL.M Michigan University), М.Халиунаа Доктор (Ph.D.), “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн Гүйцэтгэх захирал асан Ж.Эрдэнэбат, Үндэсний статистикийн хорооны статистикч Д.Батсүх нар болон Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийн Салбар дундын судлалын тэнхим, МВА хөтөлбөрийн хамт олонд талархал илэрхийлье.

## **ТОВЧ ХУРААНГУЙ**

Манай улсын эдийн засгийн хөдөлгөгч хүчний нэг нь нүүрснээс олж буй орлого байна. Уг орлогыг олох арга замыг сайжруулахын тулд Монгол Улсын Их Хурлаас 2022 онд Уул Уурхайн Биржийн тухай хуулийг баталсан. Нүүрс худалдаанд шинэ эрх зүйн орчин бий болсон энэ цаг үед нүүрсний экспортын эрх зүйн орчны судалгаа хийх шаардлага бий болоод байгаа тул энэхүү судалгааны ажлыг хийв.

Судалгааг хийхдээ өөр өөр цаг хугацааны онцлогийг гаргаж, он дарааллын дагуу Үндсэн хуулиудад эрдэс баялгийн талаар тусгасан байдал, төрөөс баримталж буй бодлогууд, хуулиудын харилцан хамаарал болон Монгол Улсын уул уурхай, нүүрс түүнийг хэрхэн экспортлох, манай улсын нүүрсний гол худалдан авагч тал болох Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ), дэлхийд нүүрсний хамгийн том олборлогч, экспортлогч орон болох Австрали, БНХАУ руу нүүрс газраар экспортолдог хойд хөрш Оросын Холбооны Улс (ОХУ)-ын эрх зүйн орчны сайн туршлагын талаар судаллаа.

Нүүрсний экспортод нөлөөлөх дараагийн хүчин зүйл нь тухайн бараа, түхий эдийн логистикийн асуудлыг ямар субъект хэрхэн тээвэрлэж буй асуудал юм. Үүнийг Монгол Улсад салбар хоорондын уялдаа холбоо, нэгдсэн ойлголт, хэрэгжүүлэх механизм, зохицуулах арга хэрэгсэл байгаа эсэх тэдгээрийг хэрхэн зөв зохистой олон улсын сайн туршлагад нийцүүлэх боломжийг тодорхойлохыг зорилоо.

Өнөөдөр дэлхийн таваарын биржүүд дээр санхүүгийн үүсмэл хэрэгсэл ашиглан эрдэс түүхий эдийн зах зээлийн үнийг нээлттэй ил, тод байдлаар тогтоосноор уул уурхайн олборлох салбарын компаниуд энэхүү тогтсон үнээр бараа бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээг худалдан авагчидтай хийдэг болсон байна.

## ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Монгол Улсын стратегийн ач холбогдол бүхий нүүрсний ордууд .....	3
Хүснэгт 2. Судалгааны ажлын нэгтгэл.....	13
Хүснэгт 3. Экспортын гол нэрийн бараа бүтээгдэхүүн, сая ам.доллороор.....	19
Хүснэгт 4. Нэгдсэн төсвийн орлого болон уул уурхайн салбарын орлого, тэрбум төгрөг .....	22
Хүснэгт 5. Гадаад худалдааны бараа эргэлтэд эзлэх хувь, ОХУ, БНХАУ, сая ам.доллороор .....	23
Хүснэгт 6. “Алсын хараа - 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжил, хүрэх түвшингийн эдийн засгийн хэсэгт уул уурхайн салбарын хүрэх түвшин .....	30
Хүснэгт 7. “Боомтын сэргэлт” хэсэгт: .....	31
Хүснэгт 8. “Аж үйлдвэржилтийн сэргэлт” хэсэгт: .....	31
Хүснэгт 9. АМНАТ Тооцох аргачлал .....	32
Хүснэгт 9. (Үргэлжлэл) АМНАТ Тооцох аргачлал.....	33
Хүснэгт 10. Нүүрсний экспорт хийхэд хэрэглэгдэх хууль болон зохицуулах харилцаа холбооны харилцан уялдааны матриц.....	35
Хүснэгт 11. Гадаадын зарим орны нүүрсний салбарын экспортын эрх зүйн орчин .....	37
Хүснэгт 12. БНХАУ-ын нүүрсний ерөнхий ангилал .....	39
Хүснэгт 13. Австралийн нүүрсний ерөнхий ангилал.....	41
Хүснэгт 14. Австралийн нүүрсний экспортын боомтууд.....	42
Хүснэгт 15. Австрали улсын Ашигт малтмал олборлох үйл явцын зохицуулалтын тогтолцоог хүснэгтэд харуулав .....	44
Хүснэгт 16. ОХУ-ын нүүрсний ерөнхий ангилал .....	45

**ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ**

Зураг 1. Монгол Улсын нүүрсний экспортын 8 томоохон компанийг харуулав. ....	6
Зураг 2. Монгол Улсын Чулуун нүүрсний экспорт, сая ам доллар, 2020-2022 он.....	20
Зураг 3. Экспортын гол нэрийн бараа бүтээгдэхүүний хилийн дундаж үнэ, ам.доллороор, сараар Алтны хилийн дундаж үнэ .....	20
Зураг 4. Гадаад худалдааны тэнцэл, тэрбум ам доллар, 2015-2022 он.....	21
Зураг 5. Нэгдсэн төсвийн орлогод нүүрсний орлогын эзлэх хувь, 2016-2022 он .....	21
Зураг 6. Нийт экспорт, тэрбум ам доллар, ДНБ-д эзлэх хувь, 1995-2021 он.....	22
Зураг 7. Экспорт бүтэц, хувиар, 1995-2021 он.....	23
Зураг 8. Экспорт, боомтоор, сая ам.доллороор.....	24
Зураг 9. Монгол, Хятадын хилийн боомтууд .....	26
Зураг 10. Дэлхийн эрчим хүчний нүүрсний худалдаа .....	36
Зураг 11. Дэлхийн коксжих нүүрсний худалдаа.....	37



**ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ**

АМНАТ-Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр

ААН-Аж ахуй нэгж

БНХАУ-Бүгд Найрамдах Хятад Ард Улс

БТКУС-Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем

ГШХО-Гадаадын шууд хөрөнгө оруулалт

ДНБ-Дотоодын нийт бүтээгдэхүүн

ОХУ-Оросын Холбооны Улс

УИХ-Улсын их хурал

УУББТХ-Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль

ҮАБҮБ-Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал

ТЭЗҮ-Техник, эдийн засгийн үндэслэл

FOB- Free On Board

FTA- Free Trade Agreement

## **УДИРТГАЛ**

Монгол Улсын уул уурхайн салбарт орох гадаадын шууд хөрөнгө оруулалт тогтвортой өсөж байгаа нь Монгол Улсын төрийн байгууллага, Засгийн газраас гадаадын хөрөнгө оруулалтыг татах бодлогыг тууштай авч хэрэгжүүлсний үр дүн юм. Монгол Улс нь дэлхийд дээгүүрт орох зэс молибден, алт, хайлуур жонш, нүүрс, газрын тос зэрэг 80 гаруй нэр төрлийн ашигт малтмалын баялаг нөөцтэй.

Дотоодын нийт бүтээгдэхүүнд 2005 оноос уул уурхайн салбарын эзлэх хувийн жин 20 гаруй хувьд хүрсэн нь сүүлийн жилүүдэд уул уурхай, олборлох салбар хурдацтай хөгжиж буйн илэрхийлэл. Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 22 хувь, Гадаадын шууд хөрөнгө оруулалтын 71 хувь<sup>1</sup>, экспортын 94 хувийг бүрдүүлж байгаа явдал нь тус салбар нь манай улсын эдийн засгийн тулгуур багана болж байна. Уул уурхайн салбараас хүртэх орлогыг ил тод байлгах, хамгийн боломжит үнээр төвлөрүүлэх нь чухал ба энэ нь Монгол Улсын уул уурхайн салбарын экспортын худалдаанд үнэ, чанар, боловсруулалт, нийлүүлэлттэй холбоотой тулгамдсан асуудлууд байна.

Монгол Улсын төсвийн орлогын 25 хувийг бүрдүүлж буй уул уурхай, эрдэс баялгийн салбарын түүхий эдийг экспортод гаргаж буй эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, үүний тулд салбарын эрх зүйн зохицуулалтаас гадна бусад салбарын зохицуулалтын орчинтой хэрхэн нийцэлтэй байгааг тодруулах шаардлага зүй ёсоор гарч байна. Тухайлбал уул уурхай, эрдэс баялгийн салбарт баримтлах төрийн бодлого нь уул уурхай эрдэс баялгийн салбарын хайх, олборлох, олборлосон бараа түүхий эдийг экспортод гаргахад дан салбарын зохицуулалтаас гадна гаалийн тарифын болон тарифын бус зохицуулалт, бараа бүтээгдэхүүний БТКУС-н код олгох чанар стандартын тогтолцоо, логистикийн тогтолцоо болон бусад салбар хоорондын зохицуулалт хамгийн чухал асуудал болоод байна.

### **Судалгааны ажлын зорилго**

Энэхүү судалгааны ажлаар Монгол Улсын уул уурхай, эрдэс баялгийн салбар дахь нүүрсний зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал, хууль, эрх зүйн орчин, экспортод гаргахад тулгарч буй хүндрэл бэрхшээл, цаашид хууль, эрх зүйн зохицуулалтын орчныг хэрхэн сайжруулах, ийнхүү сайжруулснаар бусад салбар хоорондын зохицуулалттай хэрхэн нийцэж ажиллах боломж бололцоо байгаа, хэрхэн өөрчлөлт хийх талаар Эмпирик судалгаа хийж санал, дүгнэлт боловсруулахыг зорилоо.

### **Судалгааны зорилт**

- Өнөөгийн нөхцөл байдал, (эрх зүйн орчин, тээвэр логистик, судлагдсан байдал)
- Гадаад Улсын нүүрсний салбарын эрх зүйн орчин
- Эрх зүйн орчныг сайжруулах боломжит хувилбар

### **Судалгааны арга зүй, аргачлал**

Нүүрсний экспортын эрх зүйн орчны судалгаа нь нүүрсний экспорт зах зээлд чөлөөтэй хөрвөх боломжтой болсон цаг хугацаанаас өнөөг хүртэлх ямар ямар эрх зүйн баримт үйлчилж байсан тэр нь өөрөө эдийн засгийн зах зээлд ямар байр суурь эзэлж байсныг цаг хугацааны он дарааллын дагуу судалсан судалгаа буюу longitudinal аргаар

судалсан судалгаа юм. Манай судалгаа нь Эмпирик, харьцуулалт логик анализ, ажиглалтын аргуудыг ашиглан тодорхой хэмжээнд үр дүн гаргахыг хичээлээ.

Эдгээр аргуудаас Эмпирик судалгааны аргыг илүү ашигласан. Учир нь нүүрсний зах зээл, болон түүний эрх зүйн орчны судалгааг хийхдээ бодит тоо мэдээ, эдийн засгийн ач холбогдол, байр суурь гүйцэтгэх үүрэг, баримт нотолгоонд үндэслэн дүгнэлт хийх боломжтой учир Эмпирик аргыг илүү баримталсан. Судалгааны ажлыг гүйцэтгэхдээ Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал, эрдэс баялаг, уул уурхайн салбарын түүхий эдийн үнэ ханшийн мэдээлэл өсөлт бууралт зэргийг төрөл бүрийн эх сурвалжаас түүвэр судалгааны аргаар цуглуулан авч мэдээлэл, статистикт боловсруулалт хийлээ. Мөн ном товхимол, сэтгүүл, судалгааны ажлууд, интернэт эх сурвалж зэргийг ашиглан нүүрсний салбарын экспортын хууль эрх зүйн орчин, түүнийг боловсронгуй болгох дүгнэлт, санал зөвлөмжийг дараах аргачлалыг ашиглан боловсрууллаа.

**Эмпирик арга зүй.** Энэхүү аргыг Монгол Улсын уул уурхай, эрдэс баялгийн салбарт хүчин төгөлдөр холбогдох хууль тогтоомжийн одоогийн нөхцөл байдал, практикт хэрэгжиж байгаа байдал, давуу болон сул талуудыг гаргаж ирэхээр хууль зүйн баримт бичгүүдийг ашиглаж судлав.

**Харьцуулалтын арга зүй.** Гадаадын улс орнуудын уул уурхай нүүрсний салбарын нөхцөл байдал, нөөц экспорт, импортын асуудал болон уул уурхайн салбарын тухайн улс орны эдийн засаг, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь нөлөөллийн талаар болон тухайн улс орны хууль тогтоомжийг харьцуулан судална.

**Логик анализын арга.** Тус аргын хүрээнд ерөнхий ухагдахуун ойлголт, зарчим, үндэслэл, дэлхийн улс орнуудын нүүрсний хэрэглээний байдал, цаашдын чиг хандлагыг судлахад ашиглав.

**Ажиглалтын арга.** Энэ аргыг ашиглаж манай Улсын хувьд уул уурхайн буюу нүүрсний экспортын нөхцөл байдал, энэ салбарт ямар төрлийн алдаа дутагдал илүү гарч байгааг судлахад ашиглана.

**Судалгааны шинэлэг тал.** Монгол Улсын өнөөгийн эдийн засаг уул уурхайн бүтээгдэхүүний нөөц, олборлолт, боловсруулалт болон түүний дэлхийн зах зээл дэх үнэ, экспортын нөхцөл байдлаас ихээхэн хамааралтай. Иймд уул уурхайн бус олон тулгуурт эдийн засгийг хөгжүүлэх, гадаад худалдааны экспортыг нэмэгдүүлэх зорилгоор шинэчлэл хийж, хууль тогтоомжийн актыг боловсронгуй болгох шаардлага тулгараад байна.

Цаашлаад улс орны эдийн засгийн тулгуур салбарын хөгжлийг хурдасгахыг чухалчлан үзэх болсон бөгөөд Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг баталж, зөвхөн нүүрс төдийгүй уул уурхайн бараа, бүтээгдэхүүнийг биржээр арилжих, дэлхийн жишигт хүрсэн биржтэй болох талаар ажиллаж байгаа нь сайшаалтай хэрэг тул судалгааны багийн зүгээс энэхүү асуудлыг одоогийн нийгэмд тулгамдаж буй шинэлэг сэдэв гэж авч үзэн нарийвчлан судлахаар зорьсон болно.

## I БҮЛЭГ ОНОЛЫН ХЭСЭГ

### 1.1 Нүүрсний ерөнхий ойлголт

#### Салбарын тойм

Дэлхийд 250 жил хэрэглэх нүүрсний нөөц бий гэж судлаачид үздэг ба манай улсын нүүрс үүний багагүй хувийг эзэлдэг. Монгол Улс геологийн таамгаар 173,1 тэрбум тонны нүүрсний нөөцтэй. Харин судалгаагаар батлагдсан нөөц нь 31,7 тэрбум тоннд хүрээд буй. Нүүрсний нөөцийн хэмжээ 2013 онд 4,4 тэрбум, 2015 онд 4,2 тэрбум, 2017 онд 6,8 тэрбум, 2018 онд 1,3 тэрбум, 2021 онд 1,3 тэрбум тонн нүүрсээр баяжиж дэлхийд эзлэх байр сууриа ахиулсаар байна.

Нүүрсний баялаг сангаараа дэлхийд зургаан жилийн өмнө арван нэгдүгээрт бичигддэг байсан бол манай улсын хувьд долоодугаарт бичигддэг болов. Хүрэн нүүрс Монгол оронд жигд тархсан байдаг. Хангайн болон зүүн бүсэд хүрэн, төвийн бүсэд хүрэнгээс коксжих руу шилжих завсрын үе, говийн болон баруун бүсэд чулуун болон коксжих нүүрсний ордууд байршдаг.

Тавантолгой, Нарийн сухайт, Шивээ овоо, Багануурын уурхайнууд нь стратегийн ач холбогдолтой нүүрсний орд юм. Тавантолгойн орд нь 6,5 тэрбум тонны нөөцөөрөө тэргүүлдэг бол Багануур 800 сая, Нарийн сухайт 125 сая тонн, Шивээ-Овоо 2,7 тэрбум тонны нөөцтэй. Одоогоор 29 нь чулуун нүүрс, 20 нь хүрэн нүүрс нийт 49 уурхай идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаагаас гадаадын хөрөнгө оруулалттай 8 уурхайд 7 аж ахуй нэгж, дотоодын болон хамтарсан 33 уурхайд 28 аж ахуй нэгж, төрийн болон орон нутгийн өмчийн 8 уурхайд 7 аж ахуй нэгж байна.

Хүснэгт 1. Монгол Улсын стратегийн ач холбогдол бүхий нүүрсний ордууд

№	Ордын нэр	ААН, компани	Олборлох жилийн хүчин чадал /мян.төг/	Экспортолж байгаа боомт
1	Таван толгой	Эрдэнэс Монгол ХХК	35,000.0	Гашуун сухайт
		Таван толгой ХХК	2,000.0	Гашуун сухайт
		Энержи Ресурс ХХЗ	15,000.0	Гашуун сухайт
2	Нарийн сухайт	МАК ХХК	14,000.0	Шивээ хүрэн
		Чин Хуа МАК НС ХХК	2,000.0	Шивээ хүрэн
		Саусгоби сэндс ХХК	9,000.0	Шивээ хүрэн
		Өсөх зоос ХХК	3,500.0	Шивээ хүрэн
3	Багануур	Багануур ХК	4,000.0	Төвийн ЭХС
4	Шивээ-Овоо	Шивээ-Овоо ХК	2,000.0	Төвийн ЭХС

## **Нүүрсний олборлолт, борлуулалт, дотоод хэрэглээ, экспорт**

Дэлхий нийт Ковид-19 цар тахлыг даван туулж тээвэр, логистикт хүндрэлүүд буурч байна. Иймд бид цар тахлын өмнөх үеийн эдийн засгийн орчныг судаллаа.

Монгол Улс 2016 онд 35.1 сая.тн нүүрс олборлож, 25.8 сая.тн нүүрс экспортолсон. Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал олборлолт 1.4 дахин, экспорт 1.8 дахин өссөн үзүүлэлттэй байсан бол 2018 онд 51.4 сая тонн нүүрс олборлосон. Энэ нь 2017 оноос 6.8 хувиар буюу 3.3 сая тонн, 2013 оноос 70.6 хувиар буюу 21.3 сая тонн, 2009 оноос 3.6 дахин буюу 37.0 сая тонноор өссөн. Олборлосон нүүрсний 62.3 хувь буюу 32.0 сая тонныг экспортолсон нь өмнөх оноос 10.7 хувиар буюу 3.1 сая тонноор, 2013 оноос 2.5 дахин буюу 19.4 сая тонноор, 2009 оноос 4.5 дахин буюу 24.9 сая тонноор өссөнөөр экспортын тэргүүлэгч бүтээгдэхүүн нь нүүрс болсон.<sup>2</sup>

Ашигт малтмал, газрын тосны газрын мэдээгээр 2018 онд 21 аж ахуйн нэгж нүүрс экспортолж байсан бол, 2019 онд 18 аж ахуйн нэгж экспорт хийсэн байна. Өмнөговь аймагт 17 нүүрсний талбайгаас, Дорноговь аймагт 13 нүүрсний талбайгаас, Сүхбаатар аймагт 11 нүүрсний талбайгаас экспортолж байна.

Хөшөөтийн ордоос нүүрс экспортолж байгаа “Mongolia Energy Corporation” нь Хонгконгийн Хөрөнгийн биржид бүртгэлтэй.

Чулуун нүүрсийг 2018 онд тонн тутамд 77.9 ам.долларын дундаж үнээр 35.8 сая тонныг борлуулж 2.8 тэрбум ам.долларын орлого олсон. Нүүрсний экспортын үнийн дүн өмнөх оноос 529.6 сая ам.доллаароор, тоо хэмжээ 2.8 сая тонноор, дундаж үнэ 9.5 ам.доллаароор тус тус өссөн. Үүний 98.9 хувийг БНХАУ-д экспортолжээ.<sup>3</sup>

Нийт 2018 онд олборлосон нүүрсний 86.4 хувь буюу 44.4 сая тонн чулуун нүүрс, 13.6 хувь буюу 7.0 сая тонн хүрэн нүүрс эзэлж байна. Өмнөх онтой харьцуулбал хүрэн нүүрс 0.2 сая тонн буюу 3.4 хувиар, чулуун нүүрс 3.0 сая тонн буюу 7.3 хувиар тус тус нэмэгджээ. “Таван толгой”, “Энержи ресурс”, “Монгол алт” корпорацууд чулуун нүүрсийг, Багануур, Шивээ-Овоо зэрэг аж ахуйн нэгжүүд хүрэн нүүрсийг олборлодог.

Тонн нүүрсний өртөг 2018 онд 79,800 төгрөг болж, 2017 оноос 53.6 хувиар буюу 27,800 төгрөгөөр, 2013 оноос 2.2 дахин буюу 43.5 мянган төгрөгөөр, 2009 оноос 2.8 дахин буюу 51,000 төгрөгөөр өссөн байна.

Дотоодын хэрэглээнд 2018 онд дулааны цахилгаан станцуудад 81.3 хувь буюу 7.7 сая тонныг, айл өрх, орон сууц, нийтийн аж ахуйд 8.1 хувь буюу 774.1 мянган тонныг, үйлдвэр, барилгын салбарт 1.3 хувь буюу 120.1 мянган тонныг, тээвэр, холбооны салбарт 0.4 хувь буюу 38.2 мянган тонныг, бусад салбарт үлдсэн 8.9 хувь буюу 846.2 мянган тонныг тус тус хэрэглэжээ.

Гаалийн ерөнхий газрын мэдээгээр 3.07 тэрбум ам.доллаароор 36.4 сая тонн чулуун нүүрсийг 2019 онд экспортолсон байна.

Үүний дийлэнх хэсэг буюу 98 хувийг БНХАУ-д, үлдсэн багахан хэсгийг Их Британи болон Сингапурт гаргажээ. Боомтоор нь задлаад харвал Тавантолгойн бүлэг ордын нүүрсийг гаргаж байгаа Гашуунсухайт боомтоор 20.6 сая тонн нүүрс гаргасан байна. Голчлон Нарийнсухайтын бүлэг ордоос нүүрс олборлож байгаа компаниуд экспорт хийдэг Шивээхүрэн боомтын экспорт 12.4 сая тонн хүрсэн байна.

Засгийн газар 2019 онд 42 сая тонн нүүрс экспортлохоор төсөөлж байсантай харьцуулахад нүүрсний экспортын бодит хэмжээ бага буюу 36 сая тонн нүүрс экспортолжээ. Өмнөх жилүүдийнхтэй харьцуулахад урьд өмнө нь байгаагүй өндөр дүнд тооцогдож байгаа юм. Оны сүүлийн хоёр сард БНХАУ-ын талын татан авалт буурсантай холбоотойгоор нүүрсний экспорт огцом багассан байна. Гэхдээ голлох экспортлогч компаниуд өмнөх оны үзүүлэлтээ давуулсан байна. Тухайлбал: Ховдын Булганы боомтоор нүүрсээ гаргадаг “Mongolia Energy Corporation”-ийн экспорт 70 хувиар өсөж, 1.2 сая тонн болжээ.

Тавантолгойн бүлэг ордын компаниудаас “Эрдэнэс Тавантолгой” ХК хоёр сая тонноор нэмэгдэж, 13.7 сая тонн болжээ. Улмаар тус компани өнгөрсөн онд нэг их наяд төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. “Тавантолгой” ХК-ийн экспорт долоон хувиар өсөж, хоёр сая тонн болжээ. Статистик мэдээгээр 2019 онд 50.8 сая тн нүүрс үйлдвэрлэж, 3.1 тэрбум ам.долларын 36.5 сая тн чулуун нүүрс экспортолсон нь өмнөх онтой харьцуулбал тоо хэмжээний хувьд 708.6 мян.тн-оор, үнийн дүнгийн хувьд 288.1 сая ам.доллароор их байна. Тонн нүүрсний хилийн дундаж үнэ 2018 онд 77.9 ам.доллар, 2019 онд 6.4 ам.доллароор өсөж 84.3 ам.доллар болжээ.

### **БНХАУ-ын нүүрсний зах зээлийн тойм**

БНХАУ нүүрсний асар их нөөцтэй бөгөөд нүүрсний орд 600 мянган км<sup>2</sup> талбайд тархсан байдаг. Гэхдээ БНХАУ-ын өөр өөр эх үүсвэрүүд өөр өөр тоо баримт хэлдэг, нүүрсний нөөцийг тооцоолох аргачлал, нөөцийн ангилал нь тодорхой бус, дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн ангилал хэрэглэдэггүй, тоон үзүүлэлтээ байнга засварлаж байдаг зэргээс шалтгаалан нийт нөөцийн талаар бүрэн дүүрэн мэдээлэл олж авахад хүндрэлтэй.

Хамгийн их иш татдаг тоон үзүүлэлт гэвэл БНХАУ-ын нийт нүүрсний нөөц 1 их наяд /триллион/ тонн орчим, үүнээс чулуун нүүрс, антрацитийн нөөц 858,080 тэрбум тонн, хүрэн нүүрсний нөөц 128,200 тэрбум тонн. Баталгаатай нөөц 114,5 тэрбум тонн, үүнээс 62,200 тэрбум тонн нь чулуун нүүрс, антрацит, 52,300 тэрбум тонн нь хүрэн нүүрс бөгөөд тухайн Улсын хувьд 69 жил ашиглах нөөц юм.

БНХАУ-ын Нүүрсний судалгааны хүрээлэнгээс гаргасан мэдээлэлд таамагласан нөөц 5,0592 их наяд тонн, хайгуул хийж тогтоосон нөөц /ашигласан нөөцийг хасаад/ 972,4 тэрбум тонн, баталгаажсан нөөц 954,4 тэрбум тонн, үүнээс коксжих нүүрс 264,6 тэрбум тонн, антрацит 115,8 тэрбум тонн, чулуун нүүрс 391,1 тэрбум тонн, хүрэн нүүрс 123,9 тэрбум тонн гэжээ. БНХАУ-ын статистикийн мэдээнд баталгаатай нүүрсний нөөц гэж эдийн засгийн хувьд ашигтай нөөцийг /ашигласан хэсгийг нь хасаад/ 215,789 тэрбум тонн гэж тусгасан байдаг.

Гурав дахь удаагийн бүх Улсын геологийн тооллогын үр дүнд нөөцийг дахин тодруулж таамагласан нөөц 5,57 их наяд тонн, хайгуул хийж тогтоосон нөөц 1,042,135 их наяд тонн, баталгаажсан нөөц 1,003,258 их наяд тонн болсон байна.

Чулуун нүүрсний уурхай БНХАУ-ын бараг бүх нутагт тархсан байдаг бөгөөд Нүүрсний судалгааны хүрээлэнгээс гаргасан мэдээллийн дагуу Шаньси, Шэньси, ӨМӨЗО-ы чулуун нүүрсний нөөц 568,9 тэрбум тонн буюу Улсын нийт нөөцийн 59,6%, Ганьсу муж, Хөхнуурын нөөц 137,7 тэрбум тонн буюу 14,4% болж хойд болон баруун хойд бүс нутаг нүүрсний нөөцөөрөө тэргүүлдэг.

Хятад Улсын түүхий нүүрсний үйлдвэрлэл 2002-2013 онд 1.4 тэрбум тонноос 4.15 тэрбум тоннд хүрч жилд дунджаар 10.2% өссөн үзүүлэлттэй байна. 1995 оноос хойш Монгол Улс нийтдээ 336 сая тонн нүүрс экспортолсон. Үүний 80 хувь буюу 298.4 сая тонн нь 2011 оноос өдийг хүртэл экспортолсон бөгөөд нийт экспортолсон нүүрсний 90 хувийг “Эрдэнэс Тавантолгой”, “Энержи Ресурс”, “Монголын алт МАК”, “Тавантолгой”, “Саусгоби”, “Моэнко”, “Чинхуа МАК Нарийн сухайт”, “Хангад эксплорэйшн” зэрэг компаниуд экспортолсон байна.

Зураг 1. Монгол Улсын нүүрсний экспортын 8 томоохон компанийг харуулав.



Эх сурвалж: Уул уурхай хүнд үйлдвэрийн яам, Гаалийн Ерөнхий газар

Монгол Улс 1995-2022 онуудад 45.2 их наяд /336 сая.тн/ төгрөгийн борлуулалтын орлого олсон бөгөөд үүний 95 хувь буюу 43.5 их наяд төгрөгийг 2011 оноос өнөөдрийг хүртэлх хугацаанд олсон. Энэхүү орлогоос 10 их наяд төгрөгийг улсын нэгдсэн төсөвт татвар хэлбэрээр төвлөрүүлсэн байна.

## 1.2 Монгол Улсын гадаад худалдааны эрх орчин, бодлогын баримт бичгүүд

Монгол Улсад гадаад худалдааны асуудлыг зохицуулах тусгайлсан хууль одоогоор байхгүй бөгөөд гадаад худалдаанд хамаарал бүхий асуудлуудыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд дараах байдлаар зохицуулж байна. (Ц.Норовдондог, 2021 ) Тухайлбал, Гаалийн тухай хуульд бараа болон тээврийн хэрэгслийг хилээр нэвтрүүлэхэд баримтлах зарчим, гаалийн хууль тогтоомжийн талаарх мэдээлэл, зөвлөгөө, шийдвэрийн талаар гомдол гаргах, гаалийн бүрдүүлэлт хийх, барааг гаалийн нутаг дэвсгэрт оруулах, гаргах, түр хадгалах, мэдүүлэх, мэдүүлсэн барааг олгох, дотоодын хэрэглээнд зориулан оруулах горим, хилийн чанадад гаргах горим, баталгаат бүсийн горим, баталгаат агуулахын горим, баталгаат үйлдвэрийн газрын горим, чөлөөт бүсийн горим, оюуны өмчийн эрхэд хамаарах барааг хилээр нэвтрүүлэхтэй холбоотой харилцааг;

- Гаалийн татвар тарифын тухай хуульд барааны ангилал, импортын барааны гарал үүсэл, экспортын болон импортын барааны гаалийн үнийг тодорхойлох, гаалийн татвар тогтоох хэлбэр, бусад татвар ногдуулах, хураах, төлөх зэрэг гадаад худалдаатай холбоотой харилцааг; - Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай

/Шинэчилсэн найруулга/ хуульд Монгол Улсад импортоор оруулсан болон экспортод гаргасан бараа, ажил, үйлчилгээнд ногдуулах татварын хувь хэмжээний талаарх асуудлыг;

- Онцгой албан татварын тухай (Шинэчилсэн найруулга) хуульд Монгол Улсад импортоор оруулсан зарим төрлийн бараанд ногдуулах онцгой албан татварын хувь хэмжээ, мөн уг татвараас чөлөөлөгдөх экспорт, импортын барааны талаарх асуудлыг;
- Чөлөөт бүсийн тухай хуульд зааснаар чөлөөт бүс байгуулах болон өөрчлөх мөн татан буулгах, чөлөөт бүсийн байршил, хяналтын тогтолцоо, удирдлагын эрх хэмжээ, чөлөөт бүсэд мөрдөх гааль, татвар, шалган нэвтрүүлэх, иргэний болон хуулийн этгээдийн бүртгэл, эрх зүйн бусад харилцааг;

Түүнчлэн, Иргэний хууль, Компанийн тухай /Шинэчилсэн найруулга/, Шударга өрсөлдөөний тухай, Газрын тухай зэрэг хуулиуд, мөн банк, харилцаа холбоо, ашигт малтмал, оюуны өмчийн эрхтэй холбоотой бусад хуулиуд болон олон улсын гэрээ, гадаад орнуудтай байгуулсан худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээрүүд, Монгол Улсын бодлогын баримт бичгүүдээр Монгол гадаад худалдааны бодлого, хууль эрх зүйн орчин тодорхойлогдож байна.

### **1.3 Судлагдсан байдлын судалгаа**

Монгол Улсын нүүрсний салбарын судалгааны талаар. Нүүрсний талаар судлаачид олон судалгаа хийсэн байгаа бөгөөд үүнийг хугацааны хувьд дараах байдлаар ангилж авч үзлээ. Үүнд:

*2000-2010 онуудад хийгдэж байсан судалгаанууд. Эдгээрээс тоймлон авч үзвэл:*

а. “Монгол Улсын эрдэс баялгийн цогцолборуудын хөгжлийн стратеги” (П.Очирбат, 1999) бүтээлд уул уурхай, эрдэс баялгийн салбарын стратегийн зорилтыг тодорхойлж, уул уурхайн салбарыг түлш-эрчим хүч, уул төмөрлөг, нүүрс-хими, уул-хими зэрэг цогцолбор хэлбэрээр урт хугацааны төлөвлөлтийн дагуу хөгжүүлэхээр судалсан байна.

б. “Нүүрсний ил уурхайн уулын ажлын төлөвлөлт, горимын болон параметрийн оновчлол” (С.Цэдэндорж, 2000 ) бүтээлд ил уурхайн уулын ажлын төлөвлөлт, ашиглалтын технологийн сонголт нь уг ордын геологийн нөхцөл, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай харилцан хамааралтайг судалж, тэдгээр үзүүлэлтийг хэрхэн оновчтой байлгах арга замыг тодорхойлжээ.

в. “Уул уурхайн үйлдвэрийн удирдлагын арга барилыг төгөлдөржүүлэх зарим асуудлууд” (Л.Дамдинсүрэн, 2008)

г. “Нүүрсний зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, Нүүрсний экспортыг нэмэгдүүлэх боломж, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл” 2009 он. Энэхүү судалгааны ажлыг УИХ-ын Тамгын Газрын дэргэдэх Судалгаа шинжилгээ, олон нийттэй харилцах төвөөс ажлын хэсэг гарч гүйцэтгэсэн байна. Тус судалгааны ажлаар “Таван толгойн нүүрсний орд нь Цанхи, Зүүн буюу Онч Хараат, Бортолгой, Баруун өмнө, Бортээг, Баруун Наран, Ухаа худаг гэсэн хэсгүүдээс бүрддэг байна. Дээрх ордуудын нөөц, техникийн нөхцөл зэргийг авч үзэхэд бие даасан ил уурхай ажиллуулах нь геологийн хэсэг бүрд боломжтой бөгөөд



40-50 сая.тн нүүрс жилд олборлож болох тооцоо гарсан. Таван Толгойн орд газарт урьд нь Улсын хөрөнгөөр хайгуул хийж тогтоосон нүүрсний нийт геологийн нөөцийн хэмжээ 6.4 орчим тэрбум тонн, үүний дотор коксжих нүүрсний геологийн нөөц нь 1.8 орчим тэрбум тонн байна гэж” (Н. Түвшинтөгс, 2009)<sup>4</sup> үзсэн байна.

Судлаачид, тус судалгаагаар нүүрсний үнийг барьснаас болж Монгол Улс хөрөнгө санхүүгийн хувьд хүндрэлтэй байдалд орсон, үүнээс үүдэлтэй техник технологийн шинэчлэл хоцрогдох, үйлдвэрлэлийн өртөг зардал, бүтээгдэхүүн борлуулах үнэ тарифыг хүчээр барьж, үйлдвэрлэлийн зардлыг багасгахын тулд хөрс хуулах ажлын хэмжээг үндэслэлгүйгээр бууруулдаг байна. Тоног төхөөрөмжийн шинэчлэлд шаардагдах хөрөнгө оруулалтыг хасах замаар төрийн өмчийн ноогдол ашгийг зохиомлоор нэмэгдүүлэх бодлогыг компанийн удирдлагад хүчээр тулган хүлээлгэх зэрэг удирдлага, менежментийн олон сөрөг үйл ажиллагааны эцсийн үр дүнд нүүрсний уурхайнуудын хөрс хуулалтын ажил хоцрох, нүүрсний давхаргын газрын гүний ус шүүрэлт олборлолтын түвшнээс хоцрох, ингэснээр нүүрсний чийглэг нэмэгдэж бүтээгдэхүүний чанарын гологдол гардаг байна.

Дээрх нөхцөл байдал нь эрчим хүчний үйлдвэрүүдийг түлшээр найдвартай хангахад хүндрэл учруулдаг болох нь тогтоогдсон байна. Иймд уул уурхай, түлш, эрчим хүчний болон нүүрс-химийн аж үйлдвэрийн салбарын тогтвортой хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхийн тулд нүүрсний салбарын удирдлага, менежментийн өнөөгийн тогтолцоог өөрчлөн түүнийг боловсронгуй болгон сайжруулах асуудал чухал ач холбогдолтой юм.

д. “Монгол Улсын нүүрсний салбарыг 2010 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-нд нүүрсний аж үйлдвэрийг хөгжүүлэх зорилтыг хэд хэдэн тодорхойлжээ. Тодруулбал, томоохон 14 орд газарт олборлолтыг нэмэгдүүлж, төвийн бүсийн эрчим хүчний хангамжид дээрх ордуудын хүчин чадлыг нэмэгдүүлж ашиглах, техник эдийн засгийн судалгаа хийгдсэн байсныг судалжээ.

Мөн “Монголын нүүрсний аж үйлдвэрийн хөгжлийн инновацын стратеги” (З.Сундуй, 2010) бүтээлдээ математик загварчлалын дагуу нүүрсний орд газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах үе шатны дараалал, хөгжил инновацын стратегийг тодорхойлсон байдаг. Судлаач, нүүрсний үйлдвэрлэл нь эдийн засаг, уул уурхайн салбарын тогтвортой хөгжил, бүтэц ба удирдлагын арга барил, техник, технологийн талаар судалж, салбарын өрсөлдөх чадварын хэд хэдэн хүчин зүйлийг тодорхойлж, түүнийг хэрхэн дээшлүүлэх арга зүйн судалгаа бүрэн хийгдээгүй байгааг тэмдэглэсэн байна.

**2011-2019 онуудад хийгдсэн судалгааны ажлуудыг дараах байдлаар тоймлов.:**

а. “Нүүрсний ангилал, экспорт ба зах зээлийн үнэ, татварын хувь хэмжээний талаарх зарим орны туршлага” (Ц.Батдорж, 2012)

УИХ-ын Тамгын газрын дэргэдэх Судалгааны төвийн судлаачдын хийсэн энэхүү судалгааны ажлаар нүүрс олборлолт болон экспортын хэмжээгээр тэргүүлэгч улс орнуудаас Австрали, АНУ, Индонез, ОХУ, Өмнөд Африк, Хятад улсуудыг сонгон авч нүүрсний ангилал, нөөц, экспортын хэмжээ, экспортын болон бусад татварын хувь

хэмжээ зэрэг асуудлын хүрээнд Монгол Улсын нүүрсний экспортын өнөөгийн байдалтай харьцуулан авч үзсэн<sup>5</sup> байна.

Энэхүү судалгаагаар, Дэлхийн нүүрсний холбооны (World Coal Association) мэдээлснээр одоогийн нүүрс үйлдвэрлэх түвшнээр тооцоход дэлхийн 70 орчим оронд 118 жилийн нүүрсний нөөц байна гэж тогтоосон. Урьдчилсан тооцоогоор Энэтхэг-Хятадын хойгийн бүс нутаг 2025 он гэхэд хамгийн том хэрэглэгч болох магадлал өндөр байгаа бөгөөд дээрх улсууд тус бүрдээ ойролцоогоор жилдээ 2.7 тэрбум тонн нүүрс хэрэглэдэг болно хэмээн таамаглаж байгаа юм. Дэлхийн нүүрсний хэрэглээний дундаж өсөлт 1.6 хувь байх магадлалтай.

Нийт нүүрсний зах зээл Атлантын ба Номхон далайн гэсэн үндсэн хоёр хэсэгт хуваагддаг. Атлантын бүсэд ӨАБНУ, Колумби, ОХУ, Польш, АНУ гэсэн дарааллаар гол нийлүүлэгч байдаг бол Номхон далайн бүсэд Австрали, БНХАУ, Индонези, ОХУ багтдаг. Харин импортын хэмжээгээр Атлантад ХБНГУ, Англи, Испани, Итали, ОХУ гэсэн дараалалтай байдаг, Номхон далайн бүсэд Япон, Өмнөд Солонгос, Тайван, Энэтхэг гэсэн улсууд байдаг. Энэ хоёр зах зээл экспортлох тээврийн зардлаараа харьцангуй ялгаатай байдаг ба Атлантын зах зээл дээрх нүүрсний үнийг ӨАБНУ-ын Ричард Бэй боомтын спот үнээр индикатор болгон тогтоодог бол Номхон далайн зах зээлийн үнийг Австралийн Ньюкастлын спот үнээс хамааруулан тогтоодог байна.

б. “Монголын Экспортлогчдын холбоо” ТББ-аас 2013 онд “Уул уурхайн бирж байгуулах боломж” судалгааны ажлыг гүйцэтгэсэн. Энэхүү судалгааны ажлаар Уул уурхайн салбарын олон Улсын худалдаа, хууль, эрх зүйн орчны хувьд дараах асуудлууд тулгарч байна гэж үзсэн.<sup>6</sup> Үүнд:

Манай улсын эрдэс баялгийн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үнэ өртөг, худалдаа, тоо хэмжээний тухай худалдагч, худалдан авагчдын хоорондын мэдээлэл олдоц муу, зардал өндөртэй, гэрээ хэлцэл хийх нөхцөл боломж хомс байна.

Худалдагч болон худалдан авагч нарын хооронд хийсэн гэрээний үндсэн дээр уул уурхайн гаралтай бүтээгдэхүүний арилжаа хийгдэж, дээрх гэрээнд тулгуурлан хэд хэдэн хууль тогтоомжид зааснаар татвар, төлбөр хураамжийг оногдуулж байна. Үүнээс үүдэн бүтээгдэхүүний үнэ, экспортын нөхцөл байдал тодорхой бус байх шалтгаан болж, төрөөс тавигдах хяналтыг хэрэгжүүлэхэд хүндрэл учирч, төсөвт татвар, төлбөр хэлбэрээр төвлөрүүлэх орлогыг бууруулж, эдийн засагт сөрөг нөлөө үзүүлж байна.

Манай улсын уул уурхайн бүтээгдэхүүнийг худалдан авах сонирхолтой хувь хүн хуулийн этгээд, гадаадын худалдан авагчид, хөрөнгө оруулагч нарт мэдээлэл тодорхой байхгүй байгаагаас үүдэн зах зээлийн цэвэр өрсөлдөөний зарчмаар худалдаа хийж чадахгүй байгаа нь эрдэс баялгийн бүтээгдэхүүний үнэлэмж, зах зээлийн эрэлтийг бууруулж байна.

Алт, зэс, нүүрс болон төмрийн хүдэр нь Монгол улсын төсвийн орлогыг бүрдүүлдэг бөгөөд бүтээгдэхүүний үнийн уналтаас шалтгаалсан эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэрэгслийг ашиглахгүй байгаа нь нэмэлт орлого олох боломжоо алдсан хэвээр байна.

Эрдэс болон хүдрийг баяжмалаар экспортлохоос илүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, ашигт малтмалын салбарын бодлогыг зөв тодорхойлж, шинэ ордуудын дарааллыг нарийвчлан тогтоох шаардлагатай байна.

Энэхүү ажлын гол зорилго нь уул уурхайн гаралтай бүтээгдэхүүнийг арилжих бирж байгуулах боломж, уул уурхайн бүтээгдэхүүний байршил, нөөц, олборлолт, үйлдвэрлэл, арилжаалах бүтээгдэхүүн, гаднын биржүүдийн хууль, эрх зүйн орчин, арилжаанд ашиглах арга аргачлал зэргийг үнэлэхэд чиглэгдсэн байна. (Монголын экспортлогчдын холбоо, 2013)

в. НҮБХХ-ийн захиалгаар “Хараат бус судалгааны хүрээлэн” ТББ (IRIM)-аас “Монголын уул уурхайн салбарын Авлигын эрсдэлийн үнэлгээ” судалгааны ажлаар уул уурхайн салбар дахь хайгуулын ажлын ашиглалтын өмнөх, ашиглалтын, хаалтын үе шатуудын авлигын үнэлгээ болон эрсдэлийг тодорхойлохыг зорьсон байна. Судлаачид яам, засгийн газрын агентлаг, орон нутгийн засаг захиргаа, иргэний нийгмийн байгууллагууд, уул уурхайн компаниудын төлөөлөлтэй 43 ярилцлага хийж, 70 гаруй баримт бичгийг судалж, уул уурхайн салбарын эдийн засагт оруулж буй хувь нэмэр, өнөөгийн байдал, хууль эрх зүйн орчныг тоймлон үзүүлжээ.<sup>7</sup>

Салбарын хууль эрх зүйн орчны хувьд, 30 орчим хууль, 40 орчим дүрэм, журам хэд хэдэн заавар үйлчилж байгаагаас хамгийн анхдагч эрх зүйн акт нь Богд хааны 1913 онд баталсан Олон зүйлийн уурхайг нээн шийтгэх дүрэм байсан бол сүүлийнх нь УИХ-аас 2015 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан Ашигт малтмалын тухай хууль байна. 2006 онд шинэчлэн баталсан Ашигт малтмалын тухай хуулийг өнөөг хүртэл 18 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд тус хуульд 2008 онд 1 удаа, 2009 онд 3 удаа, 2010-2011 онуудад тус бүр 2 удаа, 2012-13 онуудад тус бүр 1 удаа, 2014-2015 онуудад тус бүр 4 удаа тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан нь салбарын хувьд хууль эрх зүйн орчин тогтвортой биш, хөндлөнгийн нөлөө их байгааг харуулсаар байна.

“Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын бичиг баримт”-ын 3.7.5-д “... экспортыг нэгдсэн бодлогоор зохицуулах зорилгоор Монгол Улсын Их Хурлаас Эрдэс баялгийн бирж байгуулах гэж заасны дагуу хувийн хэвшил, төрийн хамтарсан хөрөнгө оруулалттай “МОНГОЛЫН ЭРДЭС БАЯЛГИЙН БИРЖ” ХХК-ийг 2019 оны байгуулсантай холбогдуулан **2020 оноос хойш энэ талаар хийгдсэн судалгааны ажлуудыг дараах байдлаар тоймлов:**

Тухайлбал:

а. МУИС, Бизнесийн сургууль, Доктор, профессор Ж.Чимгээ, А.Нарандарь нарын 2020 онд хийсэн “Уул уурхайн гаралтай экспортын бүтээгдэхүүний борлуулалтын үнэд нөлөөлөх хүчин зүйлийн судалгаа”-аар Гадаад худалдааны нийт эргэлт 2019 онд 13,7 тэрбум ам.долларт хүрснээс экспорт 7.6 тэрбум ам.доллар болж өмнөх оноос 7% өссөн бол импорт 6.1 тэрбум ам.доллар байсан байна. Гадаад худалдааны тэнцэл 1.5 тэрбум ам.доллаароор ашигтай гарснаар экспортын нийт орлогын 82.9%-ийг уул уурхайн гаралтай бүтээгдэхүүнээс олсон бөгөөд энэ нь дэлхийн зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарсан. Чулуун нүүрс нь экспортын гол бүтээгдэхүүн байсан ба 2019 онд 36 сая тонн чулуун нүүрсийг 3 тэрбум ам.доллаароор БНХАУ руу экспортолсон байна.

Нүүрс, төмрийн хүдэр, зэсийн баяжмал экспортолдог 300 гаруй иргэн, аж ахуй нэгжийн 2019 онд байгуулсан гадаад худалдааны гэрээг судлахад нийт экспортлогчдын 73% нь дотоодын хөрөнгө оруулалттай, 27 % нь гадаадын хөрөнгө оруулалттай иргэн, аж ахуй нэгж байна. БНХАУ-тай нийт гэрээний 90% орчим хувийг хийсэн бол үлдсэн хувь нь бусад оронтой гэрээ хийсэн ч эцсийн хүлээн авагч нь БНХАУ хэвээр байсаар

байна. Үүнээс дүгнэхэд экспортын хувьд нэг орноос хэт хамааралтай байгааг бууруулах, экспортын шинэ түнш орон олох шаардлага зүй ёсоор урган гарч байна.

Эрдэс бүтээгдэхүүнийг хамгийн бага зардлаар, өндөр үнэ хүргэж борлуулах нь их хэмжээгээр экспортлохоос худалдааны ашгийг өндөр байлгах боломжтойг судалгаа харуулсан байна. Уул уурхайн гаралтай тулд бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээг өндөр байлгаснаар улсын төсөвт төвлөрүүлэх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг нэмэгдүүлэх бүрэн боломжтой. Борлуулалтын суурь үнэлгээг гадаад худалдааны гэрээний үнээр үнэлэх, дэлхийн зах зээлийн үнээр үнэлэх нь ялгаатай байгааг бүтээгдэхүүн бүр дээр тодорхой зааглаж өгөх хэрэгцээ байгаа тул тухайн салбарын хууль эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох шаардлагатай байгааг судлаачид дахин дахин онцолсон байна. 8 (Ж.Чимгээ, 2020)

б. Монголын Эрдэс баялгийн биржийн төслийн багаас “Эрдэс баялгийн бирж байгуулах” ТЭЗҮ-г 2020 онд боловсруулсан байна. Тус Төслийн баг дотоодын болон олон Улсын уул уурхайн эрдэс баялгийн зах зээлийн өнөөгийн хөгжил, туршлагыг судлан Монгол Улсад эрдэс баялгийн үүсмэл хэрэгсэл арилждаг бирж байгуулах, түүнийг дагасан зах зээлийн дэд бүтцийг бий болгох боломж, шийдлийг эдийн засаг, эрх зүй орчны талаас тодорхойлж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ, биржийн зах зээл болон түүний дэд бүтцийг хэрхэн, ямар үе шаттайгаар бий болгох талаар төслийн багийн санал дүгнэлтийг эрх бүхий этгээдэд танилцуулах, бодлого боловсруулах, шийдвэр гаргах, төслийг хэрэгжүүлэх бүх түвшинд биржийн зах зээл, үүсмэл хэрэгслийн ач холбогдол, хүрч болох эерэг үр дүнгүүдийн талаар нэгдсэн ойлголтод хүргэх зорилготойгоор хийгдсэн<sup>9</sup> байна.

#### **Хууль тогтоомжид хийсэн дүн шинжилгээний тойм.**

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль өнгөрсөн оны 12 дугаар сард батлагдсантай холбоотойгоор цаашид нарийвчилсан зохицуулалтууд шаардлагатай болох тул энэхүү судалгааны ажлаас дэвшүүлсэн санаа тодорхой хэмжээнд судалгааны эх сурвалж болон ашиглагдах боломжтой гэж үзэж байна.

Дээрх биржийн үйл ажиллагааг зохицуулсан хуулиас гадна уул уурхайн салбарт нийт 30 гаруй хууль, 40 орчим дүрэм, журам, үйлчилж байгаа нь нүүрсний экспортод шууд болон дам байдлаар нөлөөлнө. Эдгээр хууль тогтоомжийн нэг онцлог нь эрх зүйн зохицуулалтын тогтвортой байдал харьцангуй сул байна гэж үзэхээр байна. Тухайлбал, Ашигт малтмалын тухай хуулийг 2006 онд шинэчлэн баталснаас хойш өнөөг хүртэл 18 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан нь салбарын хууль эрх зүйн орчин тогтвортой бус байгааг илтгэж байна. Монголын уул уурхайн үндэсний ассоциациас Ашигт малтмалын тухай хуульд судалгаа хийхэд, дараах эрх зүйн баримт бичгүүд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгааг дурдсан байна. Үүнд: Ашигт малтмалын тухай хуультай шууд холбогдох Хууль 52, эрх бүхий байгууллагаас баталсан тогтоол /УИХ/ 2, Засгийн газрын тогтоол 16, салбарын Сайдын тушаал 23, Агентлагаас гаргасан эрх зүйн акт 26, Ашигт малтмалын тухай хуультай холбоотой Улсын дээд шүүхийн тогтоол 1, Үндсэн хуулийн цэцийн шийдвэр 1, Шүүхийн шийдвэр 198 байгаагаас хуулийн давхардал 52, хуулийн зөрчил 36, хуулийн хийдэл 22 байна гэсэн дүгнэлт гарсан байдаг.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т эдийн засаг, өмч,

худалдаа, бизнес, санхүүгийн эрх зүйн үндсийг боловсронгуй болгох замаар өмчлөх эрхийн баталгааг алдагдуулсан хууль тогтоомж, шийдвэрүүдийг засаж сайжруулна гэж заасны дагуу 2017 онд Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар судалгааны ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг уул уурхайн салбарын хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг арилгах зорилготойгоор эрдэс баялгийн салбарт үйлчилж байгаа 10 орчим хуульд дүн шинжилгээ хийхэд, нийт 260 гаруй давхардал, 150 орчим зөрчил, 150 гаруй хийдэл байгааг олж тогтоосон байдаг. Мөн Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор Захиргааны хэргийн шүүхэд гаргах нэхэмжлэл, шийдэгдсэн маргааны тоо эрс нэмэгдсэн нь салбарын үйл ажиллагааны хууль тогтоомжийг боловсронгуй болгох тодорхой үе шатанд хуулийн заалтыг нэг мөр ойлгож хэрэгжүүлэхэд гарч буй тодорхойгүй байдлыг залруулах, салбар хоорондын хууль эрх зүйн хүрээний хамтын ажиллагааг сайжруулах шаардлага байгааг харуулж байна. “Эрдэс баялгийн салбарт үйлчилж байгаа хуулиудын давхардал, хийдэл, зөрчлүүдийг арилгаснаар хуульд олон удаа нэмэлт, өөрчлөлт оруулдаг явдал багасаж, эрх зүйн тогтвортой орчин бий болсноор хөрөнгө оруулалт нэмэгдэх, тодорхой бус зохицуулалтаас үүссэн хүндрэлтэй асуудлууд шийдэгдэх болно”<sup>10</sup> (Монголын Эрдэс баялгийн биржийн төслийн баг, 2020) гэж тусгасан байна.

в. Санхүү, эдийн засгийн их сургуулийн Эрх зүйн тэнхимийн 2022 оны төгсөгч Э.Төгс-Эрдэнэ “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн эрх зүйн зохицуулалтыг бий болгох нь” сэдвээр бакалаврын дипломын ажил бичсэн бөгөөд энэхүү ажлаар Уул уурхайн бүтээгдэхүүний бирж байгуулж, хууль эрх зүйн орчныг сайжруулснаар Монгол Улсын уул уурхайн бүтээгдэхүүний худалдаанд тулгарч байгаа асуудлыг шийдэх боломжтой болно<sup>11</sup> гэж үзсэн байна.

Энэхүү судалгааны ажлаар Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн эрх зүйн зохицуулалт ба түүний ойлголтыг системчлэн тодруулах, экспортын үнэ, чанар, нийлүүлэлт, боловсруулалтын үр ашгийг сайжруулахад шаардлагатай эрх зүйн зохицуулалтын санал боловсруулах зорилготой байсан тул энэ төрлийн үйл ажиллагааг бусад улс орнуудын хувьд хэрхэн зохицуулж байгааг авч үзсэн. Улмаар тэдгээрийн өөрийн улс орны онцлогт тохирсон эрх зүйн зохицуулалтыг хэрхэн илүү боловсронгуй болгох, цаашлаад Монгол Улсын хууль тогтоомжид тусгах боломжтой эсэхийг тодорхойлохыг оролдсон байна.

г. УУББТХ-ийн төслийг өргөн боловсруулахад ажлын хэсгийн судалсан судалгаагаар гадаад улсын уул уурхайн бүтээгдэхүүний биржийн эрх зүйн зохицуулалт, ямар байдаг талаар туршлага судлах хүрээнд БНХАУ-ын Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн сайн туршлагыг судалсан байна. Үүнээс үзэхэд биржид учирч болох хүндрэл, түүнээс хэрхэн сэргийлэх арга, бараа бүтээгдэхүүнтэй холбоотой хяналт шалгалт, хариуцлага, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн орчин үеийн арга, аргачлалыг харьцуулан, одоо манай улсад хэрэгжих биржийн үйл ажиллагааны талаар судалсан байна.

Тухайлбал, манай улсын уул уурхайн бүтээгдэхүүний бирж нь АНУ-ын Чикагогийн биржийн баримталж буй журмаар буюу Уул уурхайн бэлэн бүтээгдэхүүний болон форвард гэрээний арилжаа хийж, тодорхой хэмжээний туршлагатай болсны дараа фьючерс гэрээний худалдааг хийхээр зорьж байна. Фьючерс гэрээний худалдаа нь

биржийн үйл ажиллагааны зах зээл дээрх эрсдэлийг багасгахад нөлөөлөх хүчин зүйлийн нэг болох боломжтой юм. Түүнчлэн БНХАУ-ын Шанхайн металлын фьючерсийн биржийн эрх зүйн орчны сайн туршлагыг судлан, биржийн хөрвөх чадвар болон зуучлагчдын эрх зүйн зохицуулалт, брокерийн харилцааг сайжруулж, хэрэгжүүлэхэд тохиромжтой гэж үзжээ.

Хүснэгт 2. Судалгааны ажлын нэгтгэл

Түүхэн замнал	Судлаачийн нэр	Судалгаа хийсэн он	Судалгааны нэр	Товч утга
2000-2010 онуудад хийгдсэн судалгаа	П.Очирбат /Sc.D., проф/	1999 он	Монгол улсын эрдэс баялгийн цогцолборуудын хөгжлийн стратеги	Уул уурхайн салбарын хөгжлийг урт хугацааны төлөвлөлтийн үндсэн дээр тогтвортой хөгжүүлэх арга замыг тодорхойлох, нүүрсний орд газарт олборлолтыг нэмэгдүүлэх, төвийн бүсийн эрчим хүчний хангамжид шийдвэрлэх үүрэгтэй томоохон ордуудыг ашиглах хүчин чадлыг нэмэгдүүлэх, техник эдийн засгийн тойм судалгаа гэх мэт
	С.Цэрэндорж /доктор, PhD/	2000 он	Нүүрсний ил уурхайн уулын ажлын төлөвлөлт, горимын болон параметрийн оновчлол	
	Л.Дамдинсүрэн /доктор, PhD/	2008 он	Уул уурхайн үйлдвэрийн удирдлагын арга барилыг төгөлдөржүүлэх зарим асуудлууд	
	Р.Сундуй /Судлаач/	2009-2011 он	Монгол Улсын нүүрсний салбарыг 2010 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөө, Монголын нүүрсний аж үйлдвэрийн хөгжлийн инновацын стратеги	
2010-2019 онуудад хийгдсэн судалгаа	УИХ-ын Тамгын газрын дэргэдэх Судалгааны төв	2012 он	Нүүрсний ангилал, экспорт ба зах зээлийн үнэ, татварын хувь хэмжээний талаарх зарим орны туршлага	нүүрс ОЛБОРЛОЛТ болон ЭКСПОРТЫН ХЭМЖЭЭГЭЭР тэргүүлэгч улс орнуудыг судлах, экспортын өнөөгийн байдалтай харьцуулах
	"Монголын Экспортлогчдын холбоо" ТББ	2013 он	Монгол Улсад уул уурхайн бирж байгуулах боломж	Уул уурхайн салбарын олон улсын худалдаа, хууль эрх зүйн хувьд ҮНЭ, ТАТВАР, ТӨСВИЙН ОРЛОГО

				БУУРАХ, асуудлууд тулгарсан. БИРЖ.
	"Хараат бус судалгааны хүрээлэн" ТББ	2016 он	Монголын уул уурхайн салбарын Авлигын эрсдэлийн үнэлгээ	Хууль эрх зүйн орчин тогтвортой биш
2020 оноос хойш хийгдсэн судалгаа	Ж.Чимгээ /Доктор, профессор/, А.Нарандарь	2020 он	Уул уурхайн гаралтай экспортын бүтээгдэхүүний борлуулалтын үнд нөлөөлөх хүчин зүйлийн судалгаа	Уул уурхайн гаралтай бүтээгдэхүүний үнэ дэлхийн зах зээлийн үнийн өсөлтөөс хамааралтай, БНХАУ гол улс, хэт хамааралтай, хамгийн бага зардлаар, өндөр үнэ хүргэж борлуулах, АМНАТ орлого өсөх, гадаад худалдааны гэрээний үнэ, эрх зүйн орчныг сайжруулах
	Эрдэс баялгийн биржийн төслийн баг	2020 он	"Эрдэс баялгийн бирж байгуулах" ТЭЗҮ	Эрдэс баялгийн үүсмэл хэрэгсэл арилждаг бирж байгуулах, түүнийг дагасан зах зээлийн дэд бүтцийг бий болгох боломж, шийдлийг эдийн засаг, эрх зүй орчны талаас тодорхойлж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ, биржийн зах зээл болон түүний дэд бүтцийг хэрхэн, ямар үе шаттайгаар бий болгох, биржийн зах зээл, үүсмэл хэрэгслийн ач холбогдол, хүрч болох эерэг үр дүнгүүдийн талаар нэгдсэн ойлголтод хүргэх
	Э.Төгс-Эрдэнэ	2022 он	"Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн эрх зүйн зохицуулалтыг бий болгох нь" сэдвээр бакалаврын дипломын ажил	Уул уурхайн бүтээгдэхүүний бирж байгуулах нь Уул уурхайн бүтээгдэхүүний олон улсын худалдаанд тулгарч байгаа асуудлыг шийдвэрлэх, хууль эрх зүйн орчныг бий болгох эрх зүйн орчныг сайжруулах зайлшгүй шаардлагатай байгааг судалсан

Эх сурвалж: Судлагдсан байдлын судалгаанаас харна уу.

## **II БҮЛЭГ СУДАЛГААНЫ ХЭСЭГ**

### **2.1 Өнөөгийн нөхцөл байдал**

УИХ-аас 2016 онд батлагдсан 45 дугаар тогтоолоор “Монгол Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт санхүү, худалдаа, бизнес, эдийн засаг, өмчийн эрх зүйн үндсийг боловсруулж өмч хөрөнгөө эзэмших эрхийг алдахад хүргэсэн хууль, дүрэм, журмын шийдвэрийг засаж сайжруулахаар заасан.

Дээрх хөтөлбөрт зааснаар Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар уул уурхайн салбарын эрх зүйн орчны хуулийн хийдэл, зөрчил, давхардлыг арилгахаар судалгааны ажлын хэсгийг 2017 онд байгуулсан байна. Тус судалгааны ажлын хэсэг нь уул уурхайн салбарт хэрэгжиж байгаа 10-аад хуульд дүгнэлт хийж хуулийн хийдэл-150, зөрчил-150, давхардал-267 байгааг тогтоосон байна. Мөн АМТХ-ыг хэрэгжиж эхлэхтэй уялдан Захиргааны хэргийн шүүхээр шийдэгдсэн хэрэг, маргаан ихэссэн нь тус салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, салбарын үйл ажиллагаа шат шатандаа хууль, дүрэм журмыг хэрэгжүүлэхэд гарч байгаа тодорхой бус байдлыг засаж сайжруулах, хууль эрх зүйн хүрээнд салбар хоорондын хамтын ажиллагааны зохицуулалтыг залруулах шаардлага байгааг харуулж байна

Эрдэс баялгийн салбарт үйлчилж байгаа хуулиудын давхардал, хийдэл, зөрчлүүдийг арилгаснаар хуульд олон удаа нэмэлт, өөрчлөлт оруулдаг явдал багасаж, эрх зүйн тогтвортой орчин бий болсноор хөрөнгө оруулалт нэмэгдэх, тодорхой бус зохицуулалтаас үүссэн хүндрэлтэй асуудлууд шийдэгдэх болно.

### **Биржийн үйл ажиллагаа**

Уул уурхайн гаралтай түүхий эдийн биржийг байгуулах, эрх зүйн орчныг бүрдүүлэхэд төрийн дэмжлэг, санаачлаг чухал нөлөөтэй бөгөөд биржийн үйл ажиллагаа зах зээл дэх оролцогчдын хүсэл, хэрэгцээнд нийцэж, тогтворжсон үед биржийг нээлттэй компани болгож мэргэжлийн оролцогчид, санхүүгийн институтүүдийг хувьцаа эзэмшигчээр оролцуулах нь зах зээлийг тогтвортой хөгжүүлэх сайн сонголт болдгийг бусад биржүүдийн туршлагаас харж болно.

Биржийн үйл ажиллагаа, зах зээлийн загварыг улс орнуудын соёл, зах зээлийн онцлогт нийцүүлэн оновчтой зохион байгуулах нь амаргүй сорилт юм. Биржийн үйл ажиллагаа нь боловсон хүчний чадвараас ихээхэн хамаардаг бөгөөд зохицуулалтын орчин болон дүрэм журмын хэрэгжилт, мэргэжилтэй боловсон хүчний бэлтгэл зэрэг асуудлыг анхаарах хэрэгтэй байгааг дурдсан. Төслийн удирдлагын багийг байгуулахдаа мэргэшсэн байдал болон ажлын туршлага зэргийг харгалзан зохион байгуулах, багийн ажиллах дүрэм журмыг эхэлж батлан хэрэгжүүлэх нь төслийг амжилттай хэрэгжүүлэх үйл ажиллагаанд сайнаар нөлөөлөх бөгөөд үүнтэй холбоотойгоор нэмэлт зардал гарах боломжтой. Уул уурхайн гаралтай түүхий эдийн биржийн тэргүүн зорилго нь үүсмэл хэрэгслийн арилжаагаар эрдэс баялаг, түүхий эдийн ирээдүйд хүргэгдэх, худалдагдах үнийг тогтоох, үнийн өөрчлөлтийн эрсдэлээс өөрсдийгөө хамгаалах боломжийг нийт оролцогчдод олгох явдал юм. Үнэ тогтоох арилжааны загвар, үүсмэл хэрэгслийн стандарт, загвар болон төлбөр тооцоо, клирингийн үйл ажиллагаа нь дэлхийн нийтийн хувьд жигдэрсэн бөгөөд биржүүдийн өрсөлдөөн, зах зээлийн хөгжил нь биржийн технологи, цахим систем болоод байна.



Технологийн судалгааг илүү нарийвчлан хийж, систем суурилуулах, зах зээлд нутагшуулах оновчтой хувилбарыг тодорхойлсон гэж үзэж байна. Технологийн сонголт хийхэд нийт өртөг, хүчин чадал, бусад санхүүгийн институттэй холбогдох боломж зэрэг техникийн үзүүлэлтээс гадна тухайн системийн брэндийн үнэ цэнэ, харилцагчдын итгэл хамгийн чухал хүчин зүйл болдог. Биржийн системээс гадна Монгол Улсын газар нутаг, замын сүлжээ, ордуудын байршил, хилийн боомтуудтай холбоотойгоор логистикийн загвар, хяналтын тогтолцоо нь заавал анхаарах үйл ажиллагаа байх болно. Манай эрдэс баялаг, түүхий эдийн экспортын дийлэнх нь БНХАУ-руу 2 гол боомтоор гарч байна.

Дээрхийг дүгнэвэл, уул уурхайн түүхий эд, ялангуяа нүүрсний экспортын тээвэрлэлт, хяналтыг уг боомтуудад түшиглэн оновчтой зохион байгуулах боломжтой болохыг харуулсан шийдлийг дэвшүүлсэн болно. Уул уурхайн гаралтай түүхий эдийн биржийн гишүүнчлэл нь мэргэжлийн болон мэргэжлийн бус оролцогчид гэж ангилагдах ба мэргэжлийн оролцогчид нь бирж, клирингийн байгууллагаас тавьсан санхүүгийн болон бусад нэмэлт шаардлага, шалгуурыг хангаснаар арилжааны болон клирингийн гишүүнчлэлтэй байх боломжтой.

Түүнчлэн, уул уурхайн гаралтай түүхий эдийн биржийн бизнес загварт нийцүүлэн олон улсын бараа таваарын зохицуулалттай зах зээлийн мэргэжлийн оролцогч субъект болох арбитрчийг зах зээлд шинээр оруулж ирэхээр төлөвлөсөн бөгөөд энэ субъектийн үйл ажиллагаа, зах зээлд гүйцэтгэх үүрэг, ач холбогдлын тухай судалгааны тайлангаас дэлгэрэнгүй танилцаж болно.

Мөн агуулах, тээврийн байгууллагууд, бараа түүхий эдийн чанарыг тодорхойлох лабораториудыг биржийн зүгээс итгэмжлэх ба тоног төхөөрөмж, хүчин чадлаас хамааруулан шалгуур тогтоож, итгэмжлэлийн гэрээ байгуулж, гэрээний дагуу үүрэг хариуцлага хүлээлгэж, хяналт тавьж ажиллана гэж үзэж байна. Учир нь биржийн эдгээр итгэмжлэгдсэн байгууллагуудыг биржийн нэгдсэн системд холбох, мэдээлэл дамжуулах, арилжаанд оролцогчдын хоорондын уялдааг зохицуулахаар логистикийн цахим систем ашиглагдах нөхцөл болох юм.

Дээрх бүх мэдээлэл биржийн нэгдсэн системээр дамжин нүүрсний экспортод оролцдог мэргэжлийн байгууллагуудтай мэдээллийг цаг алдалгүй цахим хэлбэрээр солилцох боломжтой болно. Тухайлбал, нүүрсний экспорт хийхэд хилийн мэргэжлийн хяналт, гаалийн бүрдүүлэлтэд шаардлагатай мэдээллийг Биржийн системээр дамжуулан цахим хэлбэрээр солилцон хугацаа, зардал хэмнэн хяналттай болно.

### **Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам**

Яам, түүний чиг үүргийг Засгийн газрын тухай хуулиар тодорхойлсон байх бөгөөд яамны бодлого, үйл ажиллагааны стратегийн гол зорилт нь эрдэс баялгийн салбарыг хөгжүүлэх, олборлох, боловсруулах үйлдвэрүүдийн экспортыг дэмжих, эрдэс баялгийн олборлолт, боловсруулалтын хэмжээг зөв уялдуулан төлөвлөх, эрдэс баялгийн бүтээгдэхүүний борлуулалтыг нээлттэй, ил тод, зах зээлийн зарчимд нийцсэн байдлаар зохион байгуулахад чиглэгдэнэ.

Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогыг баталсантай холбогдуулж Засгийн газарт бодлогын чиг үүрэг зорилтод нийцүүлэн, уул уурхайн салбарын эрх зүйн зохицуулалтын хуулийн төслийг боловсруулж, УИХ-аар оруулан хэлэлцүүлж

хэрэгжүүлэхийг даалгаж байсан. Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7.1.1-д зааснаар тус яам нь тухайн сайдын хариуцах чиглэлийн хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, үүрэг даалгаврыг улс даяар хэрэгжүүлэн шат дараалсан үйл ажиллагаа явуулж эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд уул уурхайн асуудал эрхэлсэн сайд, яам өөрийн салбарын бодлоготой уялдуулж харьяа агентлаг, нэгжүүдэд удирдамж өгч чиглүүлэх, зохицуулах, хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт өгөх ажлыг зохицуулан явуулах үүрэгтэй юм.

Уул уурхайн гаралтай түүхий эдийн биржийн үйл ажиллагаа нь салбарын яамны баримтлах бодлого, чиглэлтэй нийцэж, түүнийг хэрэгжүүлэхэд чухал үүрэг оролцоотой байх тул яам нь биржийн үйл ажиллагааг бодлогоор дэмжиж, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх, олгогдсон эрхийнхээ хүрээнд хууль тогтоомжид өөрчлөлт оруулах төслийг боловсруулж батлуулах чиглэлээр дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах шаардлагатай. Засгийн газар болон түүний төрийн захиргааны байгууллага нь биржийн үйл ажиллагаанд хэт оролцохгүйгээр, зөвхөн бодлогын түвшинд эрх зүйн орчныг сайжруулах, уул уурхайн бүтээгдэхүүний зохицуулалтын хүрээнд ажиллах нь сайн туршлага гэдгийг гадны орны нийтлэг жишиг харуулж байна.

### **Дотоодын нийт бүтээгдэхүүн**

Олборлох салбарын түүхий эдийн үнэ олон Улсын зах зээл дээр унаснаар уул уурхайн томоохон ордуудаас орох орлого буурсан, төсвийн төслийг хэт өөдрөгөөр төсөөлж, зарлагаа өндөр төлөвлөсөнтэй холбоотойгоор 2016 онд ДНБ-ий өсөлт 1.2 хувь хүртэл буурч, оны үнээр тооцсон ДНБ 23.9 их наяд төгрөгийн гүйцэтгэлтэй, ДНБ-д уул уурхай, олборлох салбарын бүтээгдэхүүний эзлэх хувь 20.1 хувьд хүрсэн муу туршлага бидэнд бий.

Монгол Улсын 2025 он хүртэлх жилийн өсөлтийн таамаглал тогтвортой буюу 5-аас 8 хувь байх төлөвтэй байна. Дэлхийн банк болон Азийн хөгжлийн банк нь манай Улсын эдийн засгийн өсөлтийн шалтгааныг уул уурхайн салбарын өсөлттэй шууд хамааралтай болохыг онцолсон. Гадны хөрөнгө оруулалт нэлээд өссөн ч энэ нь манай улсын олборлосон нүүрсний нөөц нэмэгдсэнтэй холбоотой боловч Ковид-19 цар тахлаас болж хилээр гарах орох боомтын ажиллагаа саатаж, урд хөрш рүү хийх экспорт тасалдсантай холбоотой. Жишээ нь, 2020 онд материаллаг хөрөнгийн нөөц ДНБ-ий 8.5 хувьд хүрсэн бөгөөд дараа онд нь 13.4 хувьд хүрч өсжээ. Засгийн газар болон гадаадын шууд хөрөнгө оруулалтаас (ГШХО) эдийн засгийг сэргээх бодлогын хүрээнд олгож буй хөнгөлөлттэй зээл нь үйлчилгээний салбар болон эрдэс баялгийн салбарын хүрээнд дэмжиж олгогдсон байна.

Цаашид манай улсын эдийн засгийн өсөлт дунд хугацаанд нэлээдгүй өсөж, гадны улсуудын хөрөнгө оруулалт нэмэгдэх хандлагатай байгаа нь хөрөнгө оруулагчдынхаа итгэл үнэмшлийг алдахгүй итгэл хүлээлгэн ажиллаж байгаа явдал юм. Түүнчлэн дэлхий нийтийн эдийн засгийн өсөлт ирэх жилүүдэд тогтвортой байх төлөвтэй харагдаж байгаа нь уул уурхайн бүтээгдэхүүний үнэ ханш мөн адил тогтвортой байх нөхцөлийг бүрдүүлсээр байна.

## **Хөрөнгө оруулалт**

Бизнес регистрийн санд бүртгэлтэй, үйл ажиллагаа тогтмол явуулдаг ААН-үүдийг өмчийн хэлбэрээр нь авч үзвэл Монгол Улсын хувь иргэний эзэмшдэг ААН 89.7 хувь, төрийн болон орон нутгийн өмчийн ААН 5.8 хувь, гадаадын хөрөнгө оруулалттай ААН 4.6 хувийг тус тус бүрдүүлж байна. 2019 оны 9 дүгээр сарын байдлаар Монгол Улсад бүртгэлтэй, үйл ажиллагаа явуулж байгаа, гадаадын хөрөнгө оруулалттай болон хамтарсан 5,296 ААН бүртгэгдсэний 3.2 хувь нь олборлох салбар болох уул уурхайн үйл ажиллагаа явуулж байна.

Монгол Улсын нийт хөрөнгө оруулалтад уул уурхайн салбарын эзлэх хувийн жин сүүлийн жилүүдэд тогтвортой өсөж байгаа бөгөөд 2018 оны нийт хөрөнгө оруулалтын багцын 42 хувийг уул уурхай, олборлолтын салбарын хөрөнгө оруулалт бүрдүүлсэн.

Манай улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын мөнгөн урсгал 2019 онд 2.9 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт орж ирсэн бөгөөд уг хөрөнгө оруулалтын дийлэнх хэсэг нь буюу 72 хувь нь уул уурхай, олборлолтын салбарын хөрөнгө оруулалт байна. ГШХО-ын орох мөнгөн урсгалыг санхүүжүүлэгч улсаар нь үзвэл 1,191.8 сая ам.долларыг Канад, 114.6 сая ам.долларыг Сингапур, 104.0 сая ам.долларыг Япон, 93.6 сая ам.долларыг Хонконгоос тус тус оруулсан байна. Эрдэс баялгийн олборлох салбарын хувьд 2020 онд 14.2 хувь буюу 1.2 их наяд төгрөгөөр буурч байсан. Харин 2021 онд уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын хэмжээ 19 хувь буюу 8.7 их наяд төгрөг болж, өмнөх оноос нэмэгдсэн байна.<sup>12</sup>

## **Гадаад худалдаа**

Эрдэс бүтээгдэхүүн нь манай улсын хувьд экспортын гол нэрийн бүтээгдэхүүн ба нийт экспортын хэлбэлзэл нь дээрхээс шууд хамааралтай байдаг. 2018 онд экспорт 811.0 сая ам.доллараар өсөж 7.0 тэрбум ам.долларт хүрсэн нь эрдэс бүтээгдэхүүний экспорт өссөнтэй холбоотой. 2019 онд экспорт 7.6 тэрбум ам.доллар, импорт 6.1 тэрбум ам.доллар бөгөөд гадаад худалдааны нийт бараа эргэлт 13.75 тэрбум ам.доллар байсан байна.

Манай Улсын нийт экспортын 80.0 гаруй хувийг эрдэс баялгийн бүтээгдэхүүн бүрдүүлдэг бөгөөд эрдсийн бүтээгдэхүүний экспортыг барааны бүлгээр нь авч үзвэл чулуун нүүрс, зэсийн баяжмалын экспорт голлох хувийг эзэлдэг байна. Иймд эдгээр бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дэх үнийн хэлбэлзлээс манай Улсын гадаад худалдааны нөхцөл байдал ихээхэн хамааралтай байдаг. 2019 онд манай Улсын уул уурхайн салбарын үйлдвэрлэл харьцангуй сайн байсан ч өсөлт нь удааширсан байна. Нийт уул уурхайн экспортын 50 орчим хувийг дангаараа бүрдүүлдэг нүүрсний салбарын хувьд нүүрс экспортлогчдын гэрээний үнэ өндөр, БНХАУ-ын худалдан авагчдын эрэлт өндөр байсан.

## **Уул уурхайн салбар**

Уул уурхай, олборлох салбарын нийт үйлдвэрлэл 2019 онд 12.5 их наяд төгрөгт хүрч, 2018 оноос 1.2 их наяд төгрөгөөр өссөн байна. Уул уурхай, олборлох салбарын нийт үйлдвэрлэлийг салбарын бүтцээр нь авч үзвэл нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 41.4 хувийг нүүрс олборлолт, 49.1 хувийг металлын хүдрийн олборлолт, 8.2 хувийг газрын тос олборлолтын салбар тус тус бүрдүүлж байна. Монгол Улсын олборлосон

нүүрсний хэмжээ 2019 онд 50.8 сая.тонн болж, 2018 оноос 1.6 хувиар, нүүрсний экспортын хэмжээ 36.6 сая тонн болж, 2018 оноос 0.9 хувиар тус тус өссөн байна. Тэгвэл 2023 оны 1 сарын байдлаар 565.3 сая ам.долларын 3,533.5 мян.тн чулуун нүүрс гадагшаа борлуулсан байна. 2022 оны мөн үетэй харьцуулбал биет хэмжээгээр 2,910.1 мян.тн буюу 5.7 дахин үнийн дүнгээр 421.7 сая ам.доллар буюу 3.9 дахин өсжээ. БНХАУ-руу чулуун нүүрсний 98.1 хувийг, Сингапур Улсруу 1.3 хувийг тус тус экспортолсон байна.<sup>13</sup>

## 2.2 Гадаад худалдаа, экспорт

Эдийн засгийн салбарт найрсаг харилцааг хөгжүүлж олон улсад тэнцвэртэй, бүс нутгийн хамтын ажиллагаанд хамтран ажиллах замаар улсынхаа эдийн засгийн биеэ даасан байдлыг хангаж, дэлхийн түвшний байр сууриа хамгаалах нь гадаад худалдааны бодлогын гол чухал үндэс юм. Эдийн засгийн аюулгүй байдлыг гадаад худалдаа, интеграцийн оновчтой зөв бодлогоор томъёолон түүний зорилтыг ҮАБҮБ-ын 3.2.5.1-т “Цөөн зах зээл, цөөн нэр төрлийн бүтээгдэхүүний экспорт, импортоос хэт хамааралтай үндэсний эдийн засгийн эмзэг байдлыг бууруулна” гэж заасан байна.

2022 оны байдлаар экспорт 12.5 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оноос 35.7 хувиар өссөн буюу түүхэн дээд хэмжээнд хүрсэн байна. Тус өсөлтөд эрдэс баялгийн гаралтай бүтээгдэхүүний үнэ дэлхийн зах зээл дээр өссөн мөн нүүрсний экспортын тоо хэмжээг нэмэгдүүлж өмнөх оноос 97.5 хувиар өсөж, үнийн дүн нь 234.0 хувиар өссөн байна. 2021 онд сард дунджаар 770.6 сая ам.доллар, 2022 онд 1 045.0 сая ам.долларын экспортын бүтээгдэхүүн гадаад зах зээлд нийлүүлжээ.


Хүснэгт 3. Экспортын гол нэрийн бараа бүтээгдэхүүн, сая ам.доллаароор

Барааны нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ		2022 2021	Үнийн дүн		2022 2021
		2021	2022		2021	2022	
<b>Нийт</b>		-	-	-	<b>9 241.1</b>	<b>12 540.4</b>	<b>35.7</b>
Нүүрс	сая.тн	16.1	31.8	97.5	2 774.1	6 502.7	234.0
Боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт	т.н	17.2	19.7	14.0	1 004.5	1 127.4	12.2
Төмрийн хүдэр, баяжмал	мян.тн	7 106.2	4 732.2	-33.4	952.2	391.0	- 58.9
Боловсруулаагүй газрын тос	мян.баррель	4 348.9	2 605.7	- 40.1	273.4	241.8	- 11.5

Эх сурвалж: 1212.mn

2022 оны байдлаар нийт экспортын 51.9 хувийг нүүрс, 21.8 хувийг зэсийн баяжмал, 9.0 хувийг алт, 3.1 хувийг төмрийн хүдэр, 1.9 хувийг газрын тос эзэлж байна. Өөрөөр хэлбэл нийт экспортын 87.7 хувийг 5 төрлийн түүхийн эдийн экспорт бүрдүүлж байна.

Зураг 2. Монгол Улсын Чулуун нүүрсний экспорт, сая ам доллар, 2020-2022 он




Эх сурвалж: Уул уурхайн хүнд үйлдвэрийн яам

2022 оны байдлаар чулуун нүүрсний нийт экспортын орлогын 92.5 хувь буюу БНХАУ-аас, үлдсэн 7.5 хувь нь БНСУ болон Сингапур улсаас олсон байна. Энэ нь бусад улс орон руу экспорт хийж чадахгүй байгааг харуулж байна.


2022 оны 12 дугаар сард өмнөх сараас килограмм тутамд 3.3 мянган ам.доллаар, зэсийн баяжмалын тонн тутмын хилийн дундаж үнэ 119.3 ам.доллаар, нүүрсний тонн тутмын хилийн дундаж үнэ 8.0 америк доллароор тус бүр өсжээ.

Зураг 3. Экспортын гол нэрийн бараа бүтээгдэхүүний хилийн дундаж үнэ, ам.доллаар, сараар Алтны хилийн дундаж үнэ



Эх сурвалж: 1212.mn


Зураг 4. Гадаад худалдааны тэнцэл, тэрбум ам доллар, 2015-2022 он



Эх сурвалж: 1212.mn

Гадаад худалдааны бараа эргэлт 2022 онд 3.8 тэрбум ам.доллаароор өсөлттэй гарчээ. 3.8 тэрбум ам.долларын ашигтай гарахад нүүрсний экспортын тоо хэмжээ өссөн мөн тонн тутамд хилийн дундаж үнэ 8.0 ам.доллаароор өссөн нь нөлөөлжээ.

Зураг 5. Нэгдсэн төсвийн орлогод нүүрсний орлогын эзлэх хувь, 2016-2022 он



Эх сурвалж: 1212.mn

Нүүрсний экспортын орлого нь нэгдсэн төсвийн орлогод эзлэх хувь жилээс жилд өсөж байгаа бөгөөд 2021 онд эзлэх хувь буурсан нь цар тахлын нөлөөнөөс болж тээвэр логистик удааширсантай холбоотой. 2022 онд төсвийн нэгдсэн орлогод нүүрсний борлуулалтын эзлэх хувь нь 11.1 байгаа нь 2021 оны үеэс 5.8 нэгжээр өссөн.

Хүснэгт 4. Нэгдсэн төсвийн орлого болон уул уурхайн салбарын орлого, тэрбум төгрөг

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Нэгдсэн төсвийн орлого	5,835.0	7,958.3	10,053.6	11,936.6	10,402.0	14,255.2	18,593.1
Эрдэс бүтээгдэхүүний салбарын нийт орлого	930.8	1,831.1	2,329.4	2,920.0	2,673.4	4,114.4	4,606.9
Уул уурхайн салбар	747.5	1,595.2	2,051.5	2,621.6	2,523.0	3,845.5	4,390.2
Нүүрс	142.3	603.7	910.6	1,210.6	984.1	756.9	2,062.4
Газрын тосны салбарын орлого	134.2	198.0	222.5	232.3	102.8	198.1	161.0
Бусад орлого	49.1	59.9	55.4	66.2	47.7	70.7	55.7
Уул уурхай, олборлох салбарын УТ-т эзлэх хувь	16.0%	23.0%	23.2%	24.5%	25.7%	28.9%	24.8%

Эх сурвалж: 1212.mn


Зураг 6. Нийт экспорт, тэрбум ам доллар, ДНБ-д эзлэх хувь, 1995-2021 он



Эх сурвалж: 1212.mn

Уул уурхайн бүтээгдэхүүнээс бусад бүтээгдэхүүний экспортод эзлэх хувь 2010 онд 51 хувь байсан бол 2021 онд 7.6 хувь болж буурсан нь цаашид улам буурах хандлагатайг харуулж байна. Экспортын бүтцийг 1995-2021 онуудын хоорондох хугацаанд авч үзэхэд уул уурхайн гаралтай бүтээгдэхүүн 2007 оноос хойш дийлэнх хувийг эзлэх болсон байна.

Зураг 7. Экспорт бүтэц, хувиар, 1995-2021 он



Эх сурвалж: 1212.mn

Нийт экспортод уул уурхайн бүтээгдэхүүний эзлэх хэмжээ өндөр бөгөөд экспорт нэг зах зээлд төвлөрсөн байна. Энэ нь манай улс БНХАУ-ын эдийн засаг болон түүхийн эдийн үнийн мөчлөгөөс хэт хамааралтай хэвээр байгааг илтгэж, ҮАБҮБ-ын 3.2.5.1-д заасан үндэсний эдийн засгийн эмзэг байдлыг бууруулах зорилтыг зөрчиж байна.

Манай Улсын нийт гадаад худалдааны нийт бараа эргэлтэд 2022 оны байдлаар БНХАУ 64.3 хувийг ОХУ 12.7 хувийг тус тус эзэлж байна. Өөрөөр хэлбэл нийт гадаад худалдааны 77.0 хувийг зөвхөн хөрш 2 улстайгаа хийжээ.

Хүснэгт 5. Гадаад худалдааны бараа эргэлтэд эзлэх хувь, ОХУ, БНХАУ, сая ам.доллароор

Он	Нийт экспортод эзлэх хувь		Нийт импортод эзлэх хувь		Нийт бараа эргэлтэд эзлэх хувь	
	ОХУ	БНХАУ	ОХУ	БНХАУ	ОХУ	БНХАУ
2010	2.8	84.8	32.7	30.5	18.5	56.4
2011	2.0	92.2	24.6	30.8	15.1	56.7
2012	1.8	92.6	27.4	27.8	17.3	53.3
2013	1.4	86.8	24.6	28.7	15.3	52.0
2014	1.1	87.9	29.6	33.8	14.6	62.1
2015	1.6	83.7	26.9	36.6	13.0	62.6
2016	1.1	79.4	26.2	31.6	11.3	60.0
2017	1.1	85.6	28.1	32.9	12.2	63.9
2018	1.2	93.3	29.1	33.5	13.9	66.0
2019	0.9	89.1	28.2	33.6	13.1	64.4
2020	0.8	72.5	26.4	36.1	11.3	57.5
2021	1.2	82.7	28.6	36.8	12.9	63.1
2022	0.7	84.4	30.0	35.3	12.7	64.3


Эх сурвалж: 1212.mn



2010-2022 онуудад БНХАУ нь дунджаар нийт экспортын 85.9 хувийг эзэлж байсан бол уул уурхайн салбарын өсөлт өндөр жилүүд болох 2011-2012 онуудад нийт экспортын 92.4 хувийг БНХАУ-д экспортолж байв. ҮАБҮБ-ын 3.2.5.1-д тусгагдсан цөөн зах зээлээс хэт хамааралтай байдлыг бууруулах зорилт хэрэгжих боломжгүй, суурь нөхцөлүүд, тэвэр гэх мэт, бүрэлдээгүй байна.

Өмнөговь аймгийн Шивээхүрэн, Гашуунсухайт боомтуудаар Тавантолгойн бүлэг ордын нүүрс, Оюутолгойн зэсийн баяжмалын тэвэр дамжин өнгөрч, нийт экспортын тал хувь нь тус 2 боомтоор дамжин хийгдэж байгаа ба энэхүү хоёр боомтын экспорт, эдийн засаг дахь ач холбогдол нэмэгдсэн боловч боомтууд зэрэглэлийн хувьд хоёр талын тэвэрийн зориулалттай хэвээр байна.

Зураг 8. Экспорт, боомтоор, сая ам.доллаароор



Эх сурвалж: 1212.mn

### Нүүрсний зах зээл

2020 оны Улсын төсвийн тооцоололд нийт 42 сая тонн нүүрс экспортлохоор төлөвлөсөн нь 2019 оны батлагдсан хэмжээтэй адил байгаа бөгөөд 2018 оны гүйцэтгэлээс 6 сая тн-оор илүү байна. Нүүрс экспортолсон дундаж үнэ 1 тн нь 2018 онд 80 ам.доллар байсан бол 2019, 2020 онд 75 доллар байхаар төсөвлөсөн. Гэвч цар тахал, олон Улсын зах зээлийн хямралыг дагаад энэхүү төсвийн гүйцэтгэл буурах хүлээлттэй байна. 2020 оны 1 дүгээр улиралд уул уурхайн салбар 29.8 хувиар (858 тэрбум төгрөг) буурсан бөгөөд үүнд нүүрс олборлолт 20.8 хувьтай байсан байна. Ковид-19 цар тахалтай холбоотойгоор хилийн хориг арга хэмжээ авсан, гадаад худалдааны томоохон түнш Хятад Улсын эдийн засаг удааширсан, зарим нэр төрлийн түүхий эдийн зах зээлийн үнэ буурсан зэрэг нь энэхүү бууралтад нөлөөлж байна.

Монгол улсын нэгдсэн төсвийн орлого 2023 оны 1 сарын байдлаар 1,272 тэрбум төгрөг болж, 2022 онтой харьцуулахад 259,2 тэрбум төгрөг буюу 25,6 хувиар өссөн. Уул уурхайн салбарын улсын төсөвт төвлөрүүлсэн мөнгөн орлого 341.8 тэрбум төгрөг болсон нь, өнгөрсөн оны мөн үеэс 37.2 тэрбум төгрөг буюу 12.2 хувиар өссөн байна. Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын мэдээг, салбарын хувьд эзлэх хувиар нь: Эрдэс баялгийн салбараас 24.1 хувь буюу 306.2 тэрбум төгрөг, Тусгай зөвшөөрлийн төлбөр 0.2 хувь буюу 2.2 тэрбум төгрөг, Газрын тос 2.0 хувь буюу 25.5 тэрбум, Бусад орлого 0.6 хувь хувь буюу 7.8 тэрбум төгрөг тус тус бүрдүүлжээ. Нүүрсний уурхайн олборлох салбарын хувьд

2022 оны улсын төсөвт төвлөрүүлсэн дүн 15.8 тэрбум, 2023 оны 1 сарын байдлаар 101.1 тэрбум төгрөг буюу 85.3 (6.4 дахин), хувиар тооцвол 538.8 өссөн байна. Мөн оны 1 сарын байдлаар 5,972.6 мян.тн нүүрс үйлдвэрлэж 2022 онтой харьцуулахад 3,952.7 мян.тн буюу 3.0 дахин, өссөн үзүүлэлттэй байна.

Хүнд үйлдвэрийн салбарын хувьд 2023 оны 1 сарын байдлаар 316.9 мян.тн баяжуулсан нүүрс, 58.2 мян.тн нүүрсэн шахмал түлш тус тус үйлдвэрлэсэн бөгөөд нүүрсэн шахмал түлш өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 68.9 мян.тн буюу 54.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.<sup>14</sup>

2023 оны 1 сарын байдлаар аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2.7 дахин их наяд төгрөг болж, 2022 оны мөн үеэс 1.4 (2.2 дахин) их наяд төгрөгөөр өссөн байна. эрдэс баялгийн салбарын олборлох аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл 2.0 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.3 (2.8 дахин) их наяд төгрөгөөр өсөхөд нүүрс олборлолт 1.1 (8.9 дахин ) их наяд төгрөгөөр өссөн. Уул уурхай олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2.7 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.7 ( 2.8 дахин ) их наяд төгрөгөөр өссөн нь нөлөөлөв.

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний гадаад зах зээлд борлуулсан нийт бүтээгдэхүүн 2.4 их хаяд төгрөг буюу 98.7 хувийг эзэлж байна.


### **Салбарын онцлог**

Хятадын дотоодын үйлдвэрлэл нэмэгдсэнтэй холбоотойгоор дэлхийн зах зээл дээрх коксжих нүүрс болон эрчим хүчний нүүрсний үнэ бага түвшинд хадгалагдсан хэвээр байна. 2020 оны 3 болон 4 дүгээр саруудад дараалан буурсаар байгаа коксжих нүүрсний үнийг дэмжих бодлогын хүрээнд Австралиас авах нүүрсний импортын хоригоо Хятадын зарим боомтууд чангаруулаад байгаа бөгөөд зөвхөн худалдан авагч тал гаалийн хуудас бөглөснөөр нүүрсний тээврийг хүлээн авч байсан. Монгол Улс нийт экспортын 40 орчим хувийг эзэлдэг нүүрсээ БНХАУ-д экспортолсоор ирсэн. Тиймээс нүүрсний экспортын хэмжээ БНХАУ-ын зах зээл, эрэлтээс шууд хамаарч байна. Коксжих нүүрсний экспортоор Австрали, Индонез, ОХУ, АНУ, Өмнөд Африк зэрэг улс тэргүүлэх байр суурьтай байна. Эдгээрээс Монгол Улс 2021 онд дэлхийн нийт коксжих нүүрсний экспортын 1.5 хувийг нийлүүлсэн байна.<sup>15</sup>

Хилийн боомтын асуудлаар Монгол Улсын хэмжээнд хойд, урд хөрш орнуудтай байгуулсан гэрээ хэлэлцээрийн дагуу, Засгийн газрын тогтоолоор байгуулсан нийт 46 боомт байдгаас ОХУ-тай 29, БНХАУ-тай 13, Агаарын замын 4 боомт ажиллаж байна.

Үүний 14 - олон улсын, 11 - хоёр талын байнгын ажиллагаатай, 14 - улирлын буюу хоёр талын түр ажиллагаатай, 39 - авто замын, 3 - төмөр замын, 4 - агаарын замын боомтууд байна.

Зураг 9. Монгол, Хятадын хилийн боомтууд



Эх сурвалж: Хил хамгаалах ерөнхий газрын цахим хуудас

Биржийн үйл ажиллагааг явуулахдаа арилжаанд орсон нүүрсийг хүргэх хүргэлтийн цэгүүдийг нүүрс экспортод гаргадаг боомтууд байхаар төлөвлөх шаардлагатай. Эдгээр боомт дээр нүүрсний биет хүргэлт төвлөрөн экспортод гардаг. Хүргэлтийн цэгүүд тодорхой болсноор тээвэрлэлтийн маршрут, хоорондын зай, тээвэрлэх хугацаа, тээврийн зардал зэрэг мэдээллийг Биржийн арилжаанд орсон худалдагч, худалдан авагч нарт мэдээлэх боломжтой болно. Улмаар арилжаанд оролцогч нь энэхүү мэдээлэлд тулгуурлан өөрсдийн бизнесийн үйл ажиллагааг төлөвлөх боломжтой болно.

Мөн нүүрсийг экспортод гаргахад төрийн хяналт тавьж ажилладаг хил, гааль, мэргэжлийн хяналт зэрэг байгууллагуудад ажлаа төлөвлөх, зохион байгуулах боломж бүрдэх бөгөөд тэдгээрийн үйл ажиллагаа нээлттэй, шуурхай болох боломжтой юм. 2021 онд Монгол Улс 32.3 сая.тн нүүрс олборлож, 26,7 сая,тн-ыг борлуулсанаас 15,9 сая.тн нүүрс экспортолсон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад олборлолт 24.9 хувь, борлуулалт 34.7 хувь, экспорт 48.8 хувь болж буурсан үзүүлэлтгүйгээр Гашуун сухайт болон Шивээ хүрэнгийн боомтоор гарсан байна.

Одоогийн байдлаар БНХАУ руу төмөр замаар Тавантолгойн нүүрсийг гурван чиглэлийн замаар тээвэрлэхээр яригдаж (Таван толгой-Цагаанхад-Ганцмод, Таван толгой-Зүүнбаян-Сайншанд-Замын-Үүд-Эрээн, Таван толгой-Зүүнбаян-Ханги-Мандал) байгаа юм.

Төмөр замаар тээвэрлэсэн ачаа тээвэрлэлтийн хувьд нүүрсийг 2020 онд 8625.04 мян.тн, 2021 онд 9828.03 мян.тн, 2022 онд 11204.8 мян.тн-ыг тээвэрлэсэн бөгөөд 2021 оныг 2022 онтой харьцуулахад 114.01 хувийн өсөлттэйгөөр тээвэрлэжээ.<sup>16</sup>

Монгол Улсын “Тавантолгой төмөр зам” ХХК болон БНХАУ-ын “Чайна энержи интернэшнл” ХХК, “Баошен төмөр зам” ХХК-ийн хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг хэрэгжүүлэх зорилготой санамж бичгийн төслийг хэлэлцэн, тохиролцсоноор 2023 оны хоёрдугаар сарын 11-ний өдөр хоёр талын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, баталгаажуулсан.<sup>17</sup>

Зүүнбаян-Ханги чиглэлийн 226 км үргэлжлэх төмөр зам нь Дорноговь аймаг Сайншандын Зүүнбаян өртөөнөөс Ханги-Мандал боомттой холбогдоно. Тус төмөр зам нь ажиллаж эхэлснээр Улаанбаатар төмөр замын Ерөө өртөөнөөс БНХАУ-ын Бугат өртөө хүрэх төмөр замаар тээвэрлэх зайг 1,722 км-ээс 1,404 км болгож байгаа нь 306 км-ээр дөт болгоно. Мөн Ханги Мандал боомтын үйл ажиллагаа эхэлснээр төмөр замаар тээвэрлэх бараа бүтээгдэхүүний өсөн нэмэгдэж байгаа бараа эргэлтийн 50 хувь нь нэвтрэх боломж бүрэн нээгдэж байна. Монгол Улс экспортын шинэ гарцтай болохоороо давуу талтай ажээ.

2022 онд Монгол Улс түүхэндээ анх удаа хамгийн их буюу 32 сая тонн нүүрс экспортолж, 12 тэрбум ам.долларын орлого олжээ. “Манай улс ковидын үеийн дэглэмийг нарийн сахиж ирсний үр дүнд Хятадын талтай хийх хилийн горимыг хүндрүүлээгүй. Үүний үр дүнд экспортын орлого маш сайн нэмэгдсэн. 2023 оны хоёрдугаар сарын 15-наас эхлэн манай улс нүүрсээ уурхайн амны үнээр биш, олборлолт, тээвэрлэлтийн өртөг шингэсэн үнээр урд хөршийн хилд хүргэж, биржийн үнээр худалдан борлуулах шийдвэр гаргасан билээ.

Нүүрсний биржийн туршилтын арилжааг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан нэгдүгээр сарын 12-ний өдөр амжилттай хийсэн. 2022 оны арван хоёр дугаар сард 1 тонн нүүрсний үнэ 160 ам.доллар байсныг биржийн арилжаагаар 27 ам.доллараар өсгөсөн нь биржийн арилжааны өгөөж. Ингэснээр Улсын төсөв болон нүүрс олборлогч, тээвэрлэгч ААН-үүдийн орлого нэмэгдэх эдийн засгийн эерэг үр дүнтэй.

Туршилт амжилттай болсон тул биржийн арилжааг 2023 оны 2 дугаар сарын 15-ны өдрөөс албан ёсоор эхлүүлэхээр болсон.<sup>18</sup>

Логистик, дэд бүтцийн шийдлийн талаар Зах зээлд бараа түүхий эд нийлүүлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын экспортыг зохицуулалттай зах зээлээр дамжуулж зохион байгуулахын тулд Засгийн газар тарифын бус зохицуулалтын хүрээнд тогтоол гаргаж мөрдүүлэх, эсвэл Гашуун сухайт болон Шивээ хүрэн боомт хүртэл хүргэлтийг (FOB нөхцөлөөр) хийлгээд цааш хил гаргах тээвэрлэлтийг нэгдсэн зохион байгуулалтад оруулах боломжтой. Өөрөөр хэлбэл, биржийн арилжааны хүргэлт нь дээрх 2 боомт хүртэл байхаар зохион байгуулах, тухайн хүргэлтийг хүлээн авах боомтын терминал нь Засгийн газрын харьяанд байхаар зохион байгуулбал дээрх зохицуулалтыг хийж болно.

Дээр дурдсан 2 зохицуулалтыг зөвхөн Засгийн газар хийх бүрэн эрхтэй. Тухайлбал, Монгол Улстай БНХАУ руу нүүрсний экспортоор өрсөлддөг Австрали Улсын далайн боомтын ачих, буулгах терминал нь Засгийн газрын мэдэлд байдаг бөгөөд нүүрс экспортлох компаниуд тухайн боомтын заагдсан бассейнд өөрийн ангиллын нүүрсийг буулгах үүрэгтэй.

Нүүрсний үнэ нь Сингапурын таваарын бирж дээрх фьючерс гэрээний хаалтын үнээр ямар ангиллын, ямар стандарт шаардлага хангасан нүүрс авахаа худалдан авагч захиалгаа өгнө. Тухайн стандарт нөхцөл бүхий гэрээнд заасан нүүрсийг боомтын терминалаас ачихдаа хаанаас, ямар чанартай нүүрсийг, ямар хэмжээгээр ачихыг Засгийн газрын шууд хяналт дор боомтын терминал хариуцаж ачуулдаг. Энэ нь нэг талаас төр тухайн бараа түүхий эдийн логистик, чанар, стандартыг бүрэн хариуцах, нөгөө талаас түүхий эдийн хольцыг өөрийн хяналт дор зохион байгуулж, хяналт хийх бүрэн боломжтой болгож байдаг.

Манай Улсын хувьд ойрын жилүүдэд зөвхөн авто замаар нүүрс хүргэлт хийгдэх тул одоогийн тээвэрлэлтийн зохицуулалтыг 2 салгаж зохион байгуулбал эдийн засгийн

хувьд өндөр үр ашигтай байхаас гадна экспортыг бүрэн хяналттай явуулах боломж бүрдэнэ. Тарифын бус зохицуулалтын хүрээнд тогтоол гаргах, эсвэл боомт тус бүр дээр ачих терминалыг төр өөрийн оролцоотойгоор байгуулж, боомтоос гарах ачилт, хяналтыг хэрэгжүүлж зохицуулах боломжтой. Боомт тус бүр дээр терминал байгуулах нь хөрөнгө оруулалт, цаг хугацаа шаардах тул эхний ээлжид тогтоолоор зохицуулах шаардлагатай байна.

Манай улсын нүүрсний ангилал нь хуучин 3 төрөл, 11 ангилалтай байсан бол шинэ стандартаараа түүхий болон баяжуулсан гэсэн ерөнхий ангилалтай, 6 төрлийн 29 ангилал бүхий шинэ стандарт баталсан нь нүүрснийхээ чанар, үзүүлэлтээс хамааран өөр өөр үнэ тооцож болохоор байна.

Жишиг үнийн тооцооллоос үүсдэг нэг асуудал нь АМНАТ-ыг зах зээлийн үнэд үндэслэн тооцдог. Энэ нь бодит үнээсээ илүү өндөр байдаг. Тиймээс нүүрс ангиллын стандартыг шинэчилсэн нь бодит үнэ тогтооход илүү хялбар болгох сайн тал үүсэж байна.

Монголын нүүрсний худалдааны хамгийн том асуудал нь богинын тээвэр. Тавантолгойн уурхайгаас Цагаан хадны гаалийн хяналтын бүсэд буулгасан нүүрсийг хил хүртэл 25 км-ийн зайд зөөх асуудал “хар нүх” гэж дуудагдах болжээ. Учир нь эндээс үүдэн тээвэрлэгчид, уурхайн компаниудын ашиг илт буурч, үйл ажиллагааны тогтвортой байдал алдагддаг байна. Ялангуяа 2021 онд асуудал даамжирсан. Уурхайгаас Цагаан хад хүртэл 220 км-т тээвэрлэлтийн зардал тонн тутамд 12 доллар, гэтэл хил хүртэлх 25 км-т 25-300 ам доллар/тонны хооронд тээвэрлэлтийн өртөг хэлбэлзжээ. Чингэлэг тээврийн терминал бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхэлснээр эдгээр асуудалд эерэг өөрчлөлт гарна гэсэн хүлээлттэй байна. Засгийн газар 2023 оны 2 дугаар сараас эхлэн нүүрсийг биржээр ил тод худалдах бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн ба энэ хүрээнд Эрдэнэс Тавантолгой ХХК хоёрдугаар сард гурван удаагийн биржийн арилжааг хилийн үнээр амжилттай зохион байгуулсан.

Улсын Их Хурлаар, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль (УУББТХ) батлагдсан бөгөөд 2023 оны 7 дугаар сараас хэрэгжиж эхлэх юм. Хууль хэрэгжих хугацааг хүртэл нүүрсний биржийн арилжааг Засгийн Газрын тогтоолоор хэрэгжүүлж байна.

Уул уурхайн хүнд үйлдвэрийн яамнаас (УУХҮЯ) уг хуулийг танилцуулах, Уул уурхайн бүтээгдэхүүн худалдаалах Засгийн газрын бодлогыг БНХАУ-ын нүүрс худалдан авагч байгууллагуудад танилцуулах уулзалтыг 2023 оны 2 сард зохион байгуулсан байна.

Биржийн арилжааг тогтмолжуулж, төгөлдөржүүлснээр манай улс нүүрс тойрсон хуйвалдаан, авлига, хулгайчийг таслан зогсоож чадна. Тиймээс бид худалдан авагч тал болох БНХАУ-ын аж ахуйн нэгжүүддээ шинэ бодлогоо танилцуулж, нүүрс экспортлох ажил нь ямар нэгэн хүнээс хамааралгүй, ил тод нээлттэй биржийн арилжаанд шилжиж байгаа нь сайшаалтай.

Монгол Улсын Засгийн Газрын 466 тогтоолоор экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны журмыг баталсан, энэхүү журам батлагдсанаар нүүрсийг биржээр дамжуулан ил тод нээлттэй худалдах Зах зээлийн бодит үнэ тогтох, Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх боломж бүрдсэн юм.

Тавантолгой-Цагаан цав чиглэлийн буюу Тавантолгойгоос Ханги хүртэлх 540 км төмөр замаар 2023 оны 2 дугаар сарын 1-ний өдөр БНХАУ-руу нүүрсний туршилтын тээврийг амжилттай хийжээ.

Зүүн баян- Ханги чиглэлийн 226,9 км төмөр замыг ашиглалтад оруулсан. Тус төмөр зам нь Монгол Улсын хилд хүрсэн бөгөөд БНХАУ-тай хологдох Мандал боомтын төмөр зам хилийн цаана арав гаруй км-ийн зайд буй.

Туршилтын тээврийг Тавантолгой-Цагаанцав чиглэлийн төмөр замаар хоёр удаа тус бүр тавин вагоноор 3000 тонн буюу 6047 тонн нүүрсийг тээвэрлэн экспортолжээ.

### **2.3 Нүүрсний салбарын экспортын эрх зүйн орчин**

#### **Монгол Улсын Үндсэн хууль**

1.1 БНМАУ-ын 1924 онд батлагдсан Үндсэн Хуулийн гуравдугаар зүйлийн нэгт “БНМАУ-ын хязгаарын дотор бүхий газар ба уурхай ... ардын мэдэлд байвал зохих бөгөөд энэ тухай хувийн өмч байгуулж үл болно.<sup>19</sup>”.

1.2 БНМАУ-ын 1940 онд батлагдсан Үндсэн Хуулийн тавдугаар зүйлд “Бүх газар шороо ба түүний хөрсөн дорхи зүйлүүд ... Улсын өмч буюу нийт ардын хөрөнгө мөн болно. Эдгээрийг өмчийн хөрөнгө болгож үл болно<sup>20</sup>”.

1.3 БНМАУ-ын 1960 онд батлагдсан Үндсэн Хуулийн Аравдугаар зүйлс “Бүх газар, түүний хөрсөн доорхи баялаг ... бол Улсын өмч, өөрөөр хэлбэл бүх ард түмний хөрөнгө юм.<sup>21</sup>”

1.4 Монгол Улсын 1992 батлагдсан үндсэн хуулийн зургаадугаар зүйлийн хоёрт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий ... төрийн нийтийн өмч мөн<sup>22</sup>”

1.5 Монгол Улсын үнсэн хуульд 2019 онд орсон нэмэлт, өөрчлөлт: Төрийн урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлан байгалийн баялгийг ашиглах ба түүнээс орсон орлогыг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээх. Иргэд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байхаар хуульчилсан байна.<sup>23</sup>

Монгол Улсын 4 үндсэн хуульд байгаа тогтмол нэг бодлого нь байгалийн баялаг бол ард түмний хөрөнгө мөн гэдгийг тодорхойлсон явдал юм. Харин Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд орсон нэмэлт өөрчлөлтөөр тус баялгийн дийлэнх нь ард түмэнд ногдож байхаар зааж Үндэсний Баялагийн сангийн тухай ойлголтыг тусгасан байна.

#### **Төрийн бодлого**

Алсын хараа-2050 бодлогын баримт бичгийг Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан бөгөөд тус баримт бичигт 2021-2030 онд Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, боловсруулалтын түвшин нэмэгдсэн байна, Стратегийн орд газруудыг хилийн боомттой холбосон төмөр замуудыг барьж, уул уурхайн бүтээгдэхүүн экспортлох нөхцөлийг бүрдүүлсэн байна<sup>24</sup> гэж тус тус заасан.

Энэ ажлын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагааг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

“Нэмүү өртөг шингээсэн уул уурхай, ... логистикийг эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ” гэж заасан.

Хүснэгт 6. “Алсын хараа - 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжил, хүрэх түвшингийн эдийн засгийн хэсэгт уул уурхайн салбарын хүрэх түвшин

Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин			Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Мэдээллийн эх үүсвэр
			2025	2030	2050		
Уул уурхайн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	хувь	24.3	30.6	31.4	25.3	Эдийн засгийн салбаруудын хөгжлийн түвшинг ДНБ-д эзлэх хувиар хэмжинэ	Үндэсний статистикийн хороо, Уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

Эх сурвалж: *legalinfo.mn*

Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр<sup>25</sup>

Засгийн газрын мөрийн хөтөлбөрт Уул уурхай, хүнд үйлдвэрийг хөгжүүлэх хүрээнд ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялгийн шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлнэ гэж заасан бөгөөд энэ хүрээнд: Стратегийн ач холбогдол бүхий буюу улсын эдийн засагт шууд нөлөө үзүүлж болох ордуудын эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлнэ, Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайд өргөтгөл хийж, олборлолтын хүчин чадлыг нэмэгдүүлж өртөг, зардлыг бууруулна, Тавантолгойн нүүрсний бүлэг ордын дэд бүтцийг бүрдүүлж, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулна, томоохон ордуудыг ашиглалтад оруулж, экспортын хэмжээг нэмэгдүүлнэ, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, лиценз олголтыг олон нийтэд нээлттэй болгож, хууль зөрчиж олгосон зөвшөөрлийг хүчингүй болгоно гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан Шинэ Сэргэлтийн Бодлого<sup>26</sup>-ын баримт бичигт Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголтыг цахимжуулж, дэвшилтэт техник, технологид суурилсан, нэмүү өртөг шингэсэн уул уурхайн бүтээгдэхүүний хэмжээг дээшлүүлэн өртөг зардлыг бууруулан хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, эрдэс баялгийн баталгаат нөөцийг арвижуулахаар заасан байна.

Дээрх бодлогын баримт бичгүүдийн хүрээнд авч үзвэл ойрын хугацаанд буюу 2030 хүртэл Монгол Улс уул уурхайн салбарт суурилсан эдийн засагтай байх бөгөөд уурхайн олборлолтыг нэмэгдүүлэх, олборлосон бүтээгдэхүүнээ экспортлох дэд бүтэц, логистикийг бий болгох зорилттой байна.

## Хүснэгт 7. “Боомтын сэргэлт” хэсэгт:

№	Үйл ажиллагаа	Хүрэх дүн
1.1.6	чингэлэгт тээврийн терминал, ачиж буулгах терминал, шилжүүлэн ачих терминалуудыг Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын голлох боомтуудад барих	Терминалуудыг барьж байгуулсан байна.
1.1.7	Боомтуудын ачаа нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх нэмэлт байгууламж /дүүжин тээвэр, автомат удирдлагат тээвэр/-уудыг судалж, барих	Боомтуудын ачаа нэвтрүүлэх хүчин чадал 2-3 дахин нэмэгдсэн байна.
1.1.10	Боомт тус бүрээр Уул уурхайн бүтээгдэхүүнийг тээвэрлэх, хилээр нэвтрүүлэх тээврийн зохион байгуулалтыг төлөвлөх	Уул уурхайн бүтээгдэхүүний экспортод зарцуулах хугацаа буурсан байна.

Эх сурвалж: *legalinfo.mn*

## Хүснэгт 8. “Аж үйлдвэржилтийн сэргэлт” хэсэгт:

Нэмүү өртөг шингэсэн уул уурхайн бүтээгдэхүүний хэмжээг дээшлүүлэн эрдэс баялгийн баталгаат нөөцийг арвижуулахын тулд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголтыг бүрэн цахимжуулж, өртөг зардлыг бууруулан хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, дэвшилтэт техник, технологид суурилан ажиллах		
3.1.5	"Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн ил уурхайн аргаар ашиглах боломжгүй нөөцийг далд уурхайн аргаар ашиглаж, экспортын хэмжээг нэмэгдүүлэх	Олборлолтын хэмжээг 10 сая тонноор нэмэгдүүлж, 1500-1800 хүний ажлын байр шинээр бий болгосон байна.

**Хэм хэмжээний актууд**

Ашигт малтмалын тухай хууль<sup>27</sup> /2006.07.08/

Ашигт малтмалын тухай хууль нь нийт 11 бүлэг 66 зүйл бүхий хууль бөгөөд 2006 онд анх батлагдсанаас хойш нийт 40 удаагийн нэмэлт өөрчлөлтийг оруулсан байна. Тус хуулийн зорилт нь аж ахуйн нэгж Монгол Улсын нутаг дэвсгэрт геологийн эрэл хайгуул хийх, ашигт малтмалыг ашиглах, хайгуулын талбай, уурхайн үйл ажиллагаа явуулж буй орчныг хамгаалахтай холбогдсон харилцаа бөгөөд нүүрсийг экспортлоход хуульд заасны дагуу аж ахуйн нэгж Ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр, Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тус тус төлдөг.

Тус хуульд заасны дагуу Ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр нь уурхайн талбайн гектар тутамд 21,750 төгрөг байдаг бол дотоодын үйлдвэрлэлийн зориулалттай шохойн чулуу, нүүрс, ашигт малтмалын хувьд гектар тутамд 7,250 төгрөг байдаг.

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тооцохдоо дотоодын хэрэгцээнд суурилан олборлосон бол борлуулалтын үнэлгээний 2.5 хувь; бусад бүх төрлийн ашигт



малтмалын нөөц ашигласны төлбөр тухайн бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 5.0 хувиар тооцдог. Энэхүү заалтын маргаан дагуулсан, тодорхой бус зохицуулалт нь бүтээгдэхүүний борлуулалтын үнийг тогтоох явдал байдаг.

Мөн дээрх хувь дээр бүтээгдэхүүний боловсруулалтын түвшин, зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарч доор дурдсан хувийг нэмэгдүүлж тооцдог.

#### Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр:

Ашигт малтмал буюу алт, зэс, нүүрс г.м металлуудыг эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааг Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж байгууллагууд тусгай зөвшөөрлийн үндсэн дээр хэрэгжүүлэх бөгөөд “ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр”-ийг сар бүрийн 20-ны дотор төлөх үүрэг хүлээсэн байдаг. Мөн энэхүү татвар нь бусад татвар, төлбөрүүдээс чөлөөлөх үндэслэл болдоггүй.

Ашигт малтмалын нөөц ашиглана гэдэг нь түүнийг олборлох, баяжуулах, худалдах, худалдахаар ачуулах, экспортлох зэрэг үйл ажиллагааг хамруулсан цогц ойлголт бөгөөд нөөц ашигласны төлбөр буюу рояалтиг ногдуулахдаа ашигт малтмалын нэр төрөл, боловсруулалтын түвшин, зах зээлийн үнийг харгалзан холбогдох хууль тогтоомж, төлбөр тооцох, ногдуулах аргачлалд үндэслэдэг. Нүүрс, нүүрснээс гаргаж авсан бүтээгдэхүүний АМНАТ-ийг хуульд заасан хувь дээр тухайн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн өсөлт, нэр төрлөөс хамаарч хувийг нэмэгдүүлж тооцно. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тооцох аргачлалыг хүснэгтээр харуулав.

#### Хүснэгт 9. АМНАТ Тооцох аргачлал

№	Бүтээгдэхүүний нэр төрөл	Хэмжих нэгж	Жишиж үнэлэх бүтээгдэхүүн	Зах зээлийн үнийн түвшин /ам.доллараар/	Бүтээгдэхүүний боловсруулалтын түшингээс хамаарч үндсэн хувь дээр нэмж ногдуулах хувь		
					Хүдэр	Баяж мал	Бүтээг дэхүүн
1	Боловсруулаагүй нүүрс	тн	Нүүрс	0-25 хүртэл	0.00	-	
				25-50 хүртэл	1.00		
				50-75 хүртэл	2.00		-
				75-100 хүртэл	3.00		
				100-125 хүртэл	4.00		
				125 ба түүнээс дээш	5.00		
2	Баяжуулсан нүүрс	тн	Нүүрс	0-100 хүртэл	-	0.00	-
				100-130 хүртэл	-	1.00	-
				130-160 хүртэл	-	1.50	-

	(хуурай болон нойтон аргаар технологийн боловсруулалт хийсэн)			160-190 хүртэл	-	2.00	-
				190-210 хүртэл	-	2.50	-
				210 ба түүнээс дээш	-	3.00	-
3	Эцсийн бүтээгдэхүүн (хагас кокс, кокс, хий, шингэн түлш, нүүрс-химийн бүтээгдэхүүн)	тн	Кокс	0-160 хүртэл	-	-	0.00
				160-190 хүртэл			0.50
				190-210 хүртэл			1.00
				210-240 хүртэл			1.50
				240-270 хүртэл			2.00
				270 ба түүнээс дээш			2.50

Эх сурвалж: *legalinfo.mn*

Хүснэгт 9. (Үргэлжлэл) АМНАТ Тооцох аргачлал

№	Бүтээгдэхүүний нэр төрөл	Хэмжих нэгж	Жишиж үнэлэх бүтээгдэхүүн	Зах зээлийн үнийн түвшин /ам.доллороор/	Үндсэн хувь дээр нэмж ногдуулах хувь
1	Боловсруулаагүй нүүрс	тн	Нүүрс	0-25 хүртэл	0.00
				25-50 хүртэл	1.00
				50-75 хүртэл	2.00
				75-100 хүртэл	3.00
				100-125 хүртэл	4.00
				125 ба түүнээс дээш	5.00
2	Баяжуулсан нүүрс (хуурай болон нойтон аргаар технологийн боловсруулалт хийсэн)	тн	Нүүрс	0-100 хүртэл	0.00
				100-130 хүртэл	1.00
				130-160 хүртэл	1.50
				160-190 хүртэл	2.00
				190-210 хүртэл	2.50
				210 ба түүнээс дээш	3.00
3	Эцсийн бүтээгдэхүүн (хагас кокс, кокс, хий, шингэн түлш, нүүрс-химийн бүтээгдэхүүн)	тн	Кокс	0-160 хүртэл	0.00
				160-190 хүртэл	0.50
				190-210 хүртэл	1.00
				210-240 хүртэл	1.50
				240-270 хүртэл	2.00
				270 ба түүнээс дээш	2.50

Эх сурвалж: *legalinfo.mn*

Нүүрсний нөөц ашигласны төлбөр борлуулалтын үнэлгээг тогтоохдоо тухайн металлын олон Улсын болон дотоодын зах зээлийн ханшийн үнийг баримталдаг.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль<sup>28</sup> /2022.12.23/

“Нүүрсний хулгай” гэх явдал Монгол Улсын 2022 оны хамгийн халуун сэдвүүдийн нэг байсан төдийгүй уг явдлаас болж Улсын ерөнхий прокуророос Улсын Их хурлын 3 гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх саналыг Улсын Их хуралд хүргүүлээд байгаа билээ. Энэ явдлаас болж Засгийн Газраас УИХ-д Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг өргөн мэдүүлж УИХ богино хугацаанд тухайн хуулийг баталж 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр байна.

Тус хуулийн зорилго нь Монгол Улсын уул уурхайн бүтээгдэхүүний арилжааг нээлттэй ил тод, шударгаар зохион байгуулж, зах зээлийн бодит үнэ тогтоох, эрдэс балгын экспортыг нэгдсэн бодлогоор зохицуулснаар уул уурхайн салбарт хөрөнгө оруулах сонирхлыг нэмэгдүүлж эдийн засгийн өсөлтөд салбарын оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх юм.

Хуулийн дагуу уул уурхайн биржийг байгуулж тус биржээр бүтээгдэхүүнийг арилжаалахад спот, форвард, фьючерс, опцион гэрээ гэсэн 4 төрлийн санхүүгийн үүсмэл хэрэгсэл ашиглан арилжаа явуулахаар тусгасан.

Спот гэрээ гэж бүтээгдэхүүнийг шууд худалдах, худалдан авах санхүүгийн үүсмэл хэрэгслийг хэлдэг бөгөөд үүнийг хөдөө аж ахуйн бирж өдөр тутмын арилжаанд ашиглаж байна.

Форвард гэрээ гэж бүтээгдэхүүнийг тохиролцсон нөхцөлөөр, тогтоосон хугацаанд биет байдлаар ирээдүйд нийлүүлэх, төлбөр төлөх санхүүгийн хэрэгслийг хэлдэг бөгөөд энэхүү хэрэгслийг нээлттэй биржийн арилжаанд ашигладаггүй.

Фьючерсийн гэрээ гэж талууд тодорхой хөрөнгийг тогтоосон хугацаанд урьдчилан тохиролцсон үнээр худалдах, худалдан авах үүргийг талуудад үүсгэх санхүүгийн үүсмэл хэрэгслийг хэлдэг. Энэхүү хэрэгслийг уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалахад олон улсын таваарын биржүүд ашигладаг тул монгол улсын уул уурхайн бүтээгдэхүүний бирж ашиглах нь зохимжтой.

Опцион гэрээ гэж гэрээний зүйл болох хөрөнгийг тогтоосон хугацаанд тохиролцсон үнээр худалдан авах, эсхүл худалдахыг шаардах эрхийг нэг талд үүсгэдэг ч үүргийг бий болгодоггүй. Харин худалдагч талд шаардлагыг биелүүлэх үүргийг үүсгэдэг үүсмэл санхүүгийн хэрэгслийг хэлдэг. Энэхүү хэрэгсэл нь нэг талд давуу эрх үүсгэдэг тул биржийн арилжаанд бага ашиглагддаг.

Хуульд Засгийн газрын оролцоог тусгахдаа Биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрөл, ангиллыг батлах, биржийн хувьцаа эзэмшигч байх зэргээр өргөн оролцоотойгоор тусгасан байна.

Монгол Улсад компани нүүрс экспортлоход нүүрсний үнэ тогтоох, нүүрсний ангилал, чанар стандарт, хүргэлт, нийлүүлэлт, тээвэр зууч, арилжааны зууч, биржийн гишүүнчлэл, төлбөр тооцоо, маргаан шийдвэрлэх, тээвэр болон агуулахын итгэмжлэлийн үйл ажиллагаа шаардагддаг байна. Энэхүү үйл ажиллагааг эрхлэн явуулахад 6 бие даасан хуулийн хүрээнд зохицуулагдахаар байна.

Дээрх 10 харилцаа, 6 хуулийн уялдааг хүснэгт 10-т харуулснаар Уул уурхайн биржийн тухайн хууль 8 харилцааг зохицуулахаар байна.

Хүснэгт 10. Нүүрсний экспорт хийхэд хэрэглэгдэх хууль болон зохицуулах харилцаа холбооны харилцан уялдааны матриц

№	Зохицуулагдах харилцаа	Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн хууль	Үнэт цаасны зах зээлийн тухай хууль	Гаалийн тухай хууль	Зөвшөөрлийн тухай хууль	Стандартчилал техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль	Автотээврийн тухай хууль
1	Нэгж тн.нүүрсний үнэ тогтох	+	+	+		+	
2	Ангилал чанар стандарт	+		+		+	+
3	Хүргэлт-нийлүүлэлт			+	+		+
4	Тээвэр зуучийн байгууллага			+	+		
5	Арилжааны зуучлал	+			+		
6	Гишүүнчлэл	+	+		+		
7	Клиринг тооцоолол	+	+				
8	Маргаан шийдвэрлах	+	+				
9	Итгэмжлэгдсэн тээвэр	+			+		+
10	Итгэмжлэгдсэн агуулах	+					

Эх сурвалж: Судалгааны ажлын нэгтгэсэн матриц

Монгол Улсад уул уурхайн орчны эрх зүйн харилцаа маш тогтворгүй байдаг нь Ашигт малтмалын тухай хууль батлагдсан цагаасаа хойш нийт 18 жилийн турш 40<sup>29</sup> удаа нэмэлт өөрчлөлт орж байснаас харж болохоор байна.

Иймд уул уурхайн тогтвортой, уялдаа холбоотой эрх зүйн орчин шаардлагатай байна.


## 2.4 Гадаадын зарим орны нүүрсний экспорттой холбоотой эрх зүйн орчин

Монгол Улсын нэгдэн орсон олон Улсын гэрээ гадаад орнуудтай байгуулсан худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээрүүд болон Монгол Улсын бодлогын баримт бичгүүд гадаад худалдааны хууль эрх зүйн орчныг бүрдүүлдэг.

Монгол Улс 1997 онд Дэлхийн худалдааны байгууллагад гишүүнээр элссэнээр тус байгууллагын гишүүн орнуудтай таатай үнэ тарифын нөхцөлтэйгөөр худалдаа хийх боломж бий болсон. Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орнуудын энэхүү хөнгөлөлт, таатай нөхцөлийн үр дүнд улс орнууд экспортоо нэмэгдүүлэх, олон төрлийн бараанаас сонголт хийх, үндэсний бараа бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зэрэг олон сайн талтай. Мөн Монгол Улс “Ази Номхон далайн худалдааны хэлэлцээр”-т нэгдэн орох хүсэлтээ 2009 онд илэрхийлж, 2018 онд нэгдэн орох нөхцөлийг хангасан. УИХ 2019 онд тус хуулийн төслийг соёрхон баталснаар тус хэлэлцээрт нэгдэн орсон 7 дахь гишүүн улс болсон.

2021 оны байдлаар Дэлхийн эрчим хүчний нүүрсний эхний таван экспортлогч улсуудад Индонез (43%), Австрали(20%), ОХУ (17%), Өмнөд Африк (5%), Колумб (4%) тус тус орсон байна. Харин импортлогч улсууд нь БНХАУ (27%), Энэтхэг (13%), Япон (12%), БНСУ(9%), Тайван (6%) байна.


Зураг 10. Дэлхийн эрчим хүчний нүүрсний худалдаа<sup>30</sup>



Эх сурвалж: Resources and energy quarterly: March 2023 (industry.gov.au)

Дэлхийн коксжих нүүрсний гол экспортлогч таван улсууд болох Австрали (56%), Америк (14%), ОХУ (10%), Канад (9%), Монгол (4%)-ийг экспортолсон ба гол импортлогч улсууд нь Энэтхэг (20%), БНХАУ (18%), Япон (15%), БНСУ (12%), Европын улс орнууд (12%) байна.

Зураг 11. Дэлхийн коксжих нүүрсний худалдаа<sup>31</sup>



Эх сурвалж: *Resources and energy quarterly: March 2023 (industry.gov.au)*

Монгол Улсын нүүрсний гол худалдан авагч тал мөн дэлхийн том хэрэглэгч болох БНХАУ, дэлхийн нүүрсний хамгийн том олборлогч, экспортлогч орон болох Австрали, хойд БНХАУ руу нүүрс газраар экспортолдог хойд хөрш Оросын Холбооны Улсын (ОХУ) экспорт хийх эрх зүйн орчныг судаллаа. Дэлхийн Нүүрсний ангилал, чанар стандарт, төрийн бодлого, нүүрсний экспортын эрх зүйн орчин, татварын хувь хэмжээ, нүүрсний экспорт болон худалдаалах арга хэлбэр зэрэг нь улс орон тус бүр ялгаатай байна.

Хүснэгт 11. Гадаадын зарим орны нүүрсний салбарын экспортын эрх зүйн орчин

		Монгол	ОХУ	БНХАУ	Австрали
1	Нүүрсний ангилал	2 төрөл	4 төрөл	3 төрөл	2 төрөл
2	Төрийн бодлого	Алсын хараа 2050, Шинэ Сэргэлтийн бодлого	Нүүрсний аж үйлдвэрийг 2035 он хүртэл хөгжүүлэх стратеги	Ногоон Хятад Бодлого	Муж улс тус бүр ялгаатай.

3	Нүүрсний экспортын эрх зүйн орчин	Уул уурхайн биржийн тухай хууль	Газрын хэвлийн тухай хууль, ОХУ-ын Иргэний Хууль, Олон улсын дүрэм INCOTERMS	БНХАУ-ын Нүүрсний тухай хууль, Нүүрсний экспорт, импортын хянан шалгалтын норм. Нүүрс экспортлох квотыг зохицуулах арга хэмжээ	Ашигт малтмалын тухай хууль буюу Уул уурхайн тухай хууль
4	Татвар	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 2,5-5%	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 5,5-7,5%	Нүүрсний төрлөөс хамаарч 3-6% байдаг	Муж улс бүр ялгаатай байдаг. (6.2%- 8.2%)(7%- 40%)
5	Нүүрсний экспорт	1.9 тэрбум ам.доллар	17.6 тэрбум ам.доллар	419.4 сая ам.доллар	43.9 тэрбум ам.доллар
6	Худалдах арга	Биржээр	Биржээр	Биржээр	Биржээр

Эх сурвалж: Судалгааны ажил, гадаадын зарим орны эрх зүйн орчны судалгаа

### **БНХАУ-ын нүүрсний салбарын эрх зүйн зохицуулалт**

Газарзүй геополитикийн хувьд манай улсын нүүрсний экспорт БНХАУ-аас шууд хамааралтай бөгөөд БНХАУ нь Монголын Улсын нүүрсний экспортын 90 гаруй хувийг худалдан авдаг тул БНХАУ-ийн эрх зүйн орчныг судаллаа.

### **БНХАУ руу нүүрс экспортлогч гол улсууд**

2017 онд 271 сая 120 мянга гаруй тонн нүүрс импортолсноос 187 сая 810 мянга гаруй тонн нь эрчим хүчний нүүрс, 69 сая 890 мянга гаруй тонн нь коксжих нүүрс, 13 сая 400 мянга гаруй тонн нь антрацит болсон. БНХАУ руу экспортолсон нүүрсний хэмжээгээр эхний 5 байранд орсон улсууд нь :

- Индонез 109 сая тонн;
- Австрали 80 сая гаруй тонн;
- Монгол Улс 33,9 сая тонн;
- ОХУ 28 сая гаруй тонн;
- Филиппин 5,5 сая тонн.

Эдгээрт дүн шинжилгээ хийхийн бол БНХАУ-АСЕАН-ы орнуудын чөлөөт худалдааны гэрээний дагуу импортын нүүрсний татвар тэглэсэн зэргээс үүдэн, хэдийгээр нүүрсний чанар нь Австрали улсаас муу боловч Индонез Улс БНХАУ-ын импортын нүүрсний талаас илүү хувийг эзэлж байна.

Австрали Улсын хувьд “БНХАУ-Австрали Улсын чөлөөт худалдааны хэлэлцээр” 2015 оны 12 дугаар сарын 20-нд хүчин төгөлдөр болж эрчим хүчний нүүрсэнд 2%, коксжих нүүрсэнд 0% импортын татвар ноогдуулах болсон нь үнийн хувьд өрсөлдөх боломжийг олгож БНХАУ-ын импортын 30 орчим хувийг эзлэх болсон байна.

Монгол Улс, ОХУ-ын хувьд нүүрс экспортлох боломж их боловч ачааны машин, төмөр замын тээвэрлэлтийн өртөг өндөр, хилийн боомтын нэвтрүүлэх чадвар, дэд бүтэц хөгжөөгүй, БНХАУ-ын үндсэн хэрэглэгчид төвлөрсөн Өмнөд, Зүүн бүс нутгаас алслагдсан зэргээс шалтгаалан үнийн хувьд далайгаар импортолдог Индонез, Австралийн нүүрстэй өрсөлдөх чадвар сул байсаар байна.

### **БНХАУ-ын нүүрс импортолдог гол гаалийн боомтууд**

2017 оны гаалийн мэдээнээс харахын бол БНХАУ-ын нүүрс импортлох гол гаалийн боомт Наньжин, Наньнин, Хөх хот болж байна. Нүүрс импортлох гол гаалийн боомтууд БНХАУ-ын Зүүн Өмнөд далайн эрэг орчимд төвлөрч байна. Энэ нь уг бүс нутгийн цахилгаан станцууд ихэнх нүүрсээ импортолдог Гуанси, Гуандун, Фузянь, Жэзян зэрэг эдийн засгийн хөгжилтэй мужууд байдагтай холбоотой.

БНХАУ 2022 оны 9 дүгээр сарын байдлаар 33,05 сая тонн нүүрс импортолсон ба 2022 онд БНХАУ нийт нүүрсний 57 хувийг Индонез, ОХУ 24%, Монгол 9%, бусад улсаас 10% тус тус импортолсон байна.<sup>32</sup> Импортын нүүрсний үнэ харьцангуй хямд, олборлолтын зардал бага, тээврийн зардал бага тул гаднаас импортлох нь илүү үр ашигтай гэж үздэг.

БНХАУ-ын нүүрсний ангилал нь нүүрсний нүүрсжих зэрэг болон боловсруулалтын гүйцэтгэлийн үзүүлэлтээр ерөнхий ангиллаар ангилдаг ба нүүрсний өөр өөр шинж чанар, ашиглалтын дагуу үндсэн ангиллаасаа гадна нарийвчлан ангилдаг. БНХАУ хүрэн нүүрснээс эхлээд чанар сайтай антрацит нүүрсний нөөцтэй.

Хүснэгт 12. БНХАУ-ын нүүрсний ерөнхий ангилал<sup>33</sup>

Нүүрсний ангилал	Үсгэн тэмдэглэгээ	Ангиллын индекс	
		V daf %	PM %
Антрацит	WY	<10.0	
Битумэн нүүрс	YM	>10.0	
Хүрэн нүүрс	XM	>37.0	<50

Эх сурвалж: China Standard: GB 5751-1986 Classification of Chinese coals

Нүүрс нь БНХАУ-ын экспорт импортын хамгийн их 10 түүхий эдийн нэг бөгөөд үндэсний эдийн засгийг хөгжүүлэхэд чухал үүргийг гүйцэтгэдэг.<sup>34</sup>

### **БНХАУ-ын нүүрс экспорттой холбоотой хууль эрх зүйн орчин**

БНХАУ нь нүүрс олборлох, ашиглах, экспорт, импорттой холбоотой аливаа харилцааг дараах хууль тогтоомжийн хүрээнд зохицуулдаг байна.

БНХАУ-ын Нүүрсний тухай хууль<sup>35</sup> нь тус Улсын нүүрсний салбарын хөгжлийг стандартчилах, хуульчлах, Хятад Улсын нүүрсний хууль тогтоомжийн тогтолцоог боловсронгуй болгох, нүүрсний нөөцийг зүй зохистой хөгжүүлэх ашиглах,



хамгаалах, нүүрсний үйлдвэрлэл, бизнесийн үйл ажиллагаа болон нүүрсний салбарын хөгжлийг дэмжих, зохицуулах гол хууль юм. “Нүүрсний экспорт, импортын захиргааны хянан шалгалтын норм”<sup>36</sup> БНХАУ-ын Чанарын хяналт шалгалт, хорио цээрийн ерөнхий газраас гаргасан дүрэм, “Нүүрсний экспортлох квотыг зохицуулах арга хэмжээ”<sup>37</sup> БНХАУ-ын гадаад худалдааны хууль болон БНХАУ-ын “бараа импортлох, экспортлохыг зохицуулах журам”-ын дагуу Үндэсний хөгжил шинэтгэлийн хороо худалдааны яам, Гаалийн ерөнхий газраас боловсруулсан журам, мөн БНХАУ-ын Татвар хураах удирдлагын тухай хуулиар тус тус зохицуулагддаг байна.

Индонез, Филиппин, Австрали, Монгол Улс нь “БНХАУ болон Зүүн өмнөд Азийн орнуудын нийгэмлэг хоорондын эдийн засгийн иж бүрэн хамтын ажиллагааны суурь хэлэлцээр”, “Ази Номхон далайн худалдааны хэлэлцээр” “Чөлөөт худалдааны хэлэлцээр”-ээр, мөн БНХАУ -ын Засгийн газар, Австралийн Засгийн газар “Бүс нутгийн эдийн засгийн иж бүрэн түншлэлийн тухай” хэлэлцээр (RCEP)болон холбогдох хэлэлцээрүүдэд үндэслэж татварын хувь хэмжээг тогтоодог байна.

БНХАУ Сангийн яамны мэдээллээр 2022 оны 5-р сараас 2023 оны 3-р сарыг дуустал эрчим хүчний хангамжийг хангах үүднээс бүх нүүрсэнд импортын татварыг түр тэглэсэн байна. Нүүрсний импортын татвар нь нүүрсний төрлөөс хамаараад 3-6% байдаг байна.<sup>38</sup>

### ***АВСТРАЛИ Улсын нүүрсний салбарын эрх зүйн зохицуулалт***

Дэлхийн нүүрсний худалдааны экспортын том тоглогч нь Австрали Улс бөгөөд тус улсын эдийн засгийн бүтэц Монгол Улсын эдийн засгийн бүтэцтэй төстэй буюу уул уурхайн бүтээгдэхүүнээс тодорхой хамааралтай. Австрали улс нь уул уурхайн бүтээгдэхүүний худалдаанд үндэслэн хөгжиж чадсан улсуудын нэг тул тус улсын эдийн засгийн эрх зүйн орчныг судаллаа.

### **Нүүрсний экспорт**

Австрали бол дэлхийн хамгийн том нүүрс олборлогч, экспортлогчдын нэг. 1990-ээд оны эхэн үетэй харьцуулахад дотоодын нийт үйлдвэрлэл нь хоёр дахин нэмэгдэж, экспортын хэмжээ эрчимтэй өссөн байна. Сүүлийн арван жилийн хугацаанд нүүрс нь төмрийн хүдрийн дараа орох Австралийн хоёр дахь том экспортын бүтээгдэхүүн байсаар ирсэн.

2000-аад оны дунд үе хүртэл Австралийн нүүрсний экспортын өсөлт нь Япон болон Азийн бусад хөгжингүй эдийн засагтай орнуудаас хамааралтай байсан бол 2000-аад оны сүүлээр Хятад, Энэтхэг рүү хийх экспортын хэмжээ нэмэгдсэн.

Сүүлийн жилүүдэд өндөр хөгжилтэй орнууд болон БНХАУ-ын цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлд эзлэх нүүрсний хувь хэмжээ нь нүүрснээс татгалзаж, хийн түлшээр ажилладаг үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд нэлээд буураад байна. Харин Энэтхэг болон Азийн бусад орнуудад эрчим хүчний хэрэгцээ нэмэгдэж байгаатай холбоотойгоор нүүрсийг цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлд хэрэглэх хувь хэмжээ нэмэгджээ<sup>39</sup>

2022 оны санхүүгийн жилд Австрали 413 тэрбум доллароор экспортын орлогын шинэ дээд амжилт тогтоосон бөгөөд үүний 112.8 тэрбум долларыг нүүрсний экспорт эзэлсэн байна.

Нүүрс бол Австралийн хамгийн том эрчим хүчний нөөц бөгөөд тус улс нь дэлхийн тав дахь том үйлдвэрлэгч, хоёр дахь том экспортлогч гэж тооцогддог ба нүүрсний нөөцөөрөө гуравдугаарт ордог байна. Австралид хар нүүрсийг Квинсланд, Шинэ Өмнөд Уэльс, Баруун Австрали, Тасманид үйлдвэрлэдэг бөгөөд дийлэнх хувийг гадаад зах зээлд гаргадаг.<sup>40</sup>

Украины дайн болон дотоодын хүчин зүйлсээс шалтгаалж тус улсад байгалийн хий, нүүрсний үнэ их хэмжээгээр нэмэгдсэн<sup>41</sup>. Үүнтэй холбоотойгоор Австралийн хамгийн олон хүн амтай Нью Саут Уэльс мужийн засгийн газар эрчим хүчний үнийн өсөлтийг бууруулах зорилгоор тус Улсын нүүрсний томоохон үйлдвэрлэгчидтэй нүүрс үйлдвэрлэлийнхээ 10 хүртэлх хувийг дотооддоо нийлүүлэх шаардлага бүхий хуулийн төсөл батлахаар хэлэлцээр хийж байна.

Австралийн нүүрс нь өндөр чанарын битумэн нүүрс (хар нүүрс)<sup>42</sup> эсвэл чанар муутай хүрэн нүүрс (хүрэн нүүрс)-нээс бүрддэг.

Хүснэгт 13. Австралийн нүүрсний ерөнхий ангилал<sup>43</sup>

Нүүрсний ангилал	Бусад нэршил	Шинж чанар	Нүүрс төрөгчийн агууламж
Хүлэр		Органик тунадас. Энэ нь нүүрсний урьдал бодис гэж тооцогддог.	60% доош
Хүрэн нүүрс	Хүрэн нүүрс	Ихэвчлэн шараас хар хүрэн өнгөтэй.	60-70%
Хар нүүрс	Хагас битумэн нүүрс	Хар хүрэн өнгөтэй.	70-76%
	Битумэн нүүрс	Өтгөн, ихэвчлэн хар, хар хүрэн өнгөтэй	76-86%
	Антрацит чулуун нүүрс	Илүү хатуу, гялгар хар нүүрс.	86% дээш

Эх сурвалж: <https://www.ga.gov.au/education/classroom-resources/minerals-energy/australian-energy-facts/coal>

Австрали нь нүүрсний экспортын зургаан томоохон боомттой. Шинэ Өмнөд Уэльс мужийн Ньюкасл боомт нь Каррингтон, Коораганг гэсэн хоёр терминалаар дамжуулан дэлхийн хамгийн том нүүрс тээвэрлэх үйл ажиллагааг явуулдаг. Австрали улс нь БНХАУ-ын Гуан жөү боомт, Ба Юү Жуан боомт, Фан Чэн Ган боомт, Цао Фэй

Дянь боомт, Пү Тиан, Жан Жиан, Шянь Төү, Фү Жөү, Рү Жөү, Шя Мэнь, Ры Жао гэх боомтуудаар нүүрсээ нийлүүлдэг байна.

Хүснэгт 14. Австралийн нүүрсний экспортын боомтууд

Боомт	Муж улс	Сая тонн (2008)	Сая тонн (2009)
Newcastle	NSW	92.8	91.4
Hay Point	QLD	82.4	80.4
Gladstone	QLD	56.2	54.1
Abbot Point	QLD	14.4	12.5
Port Kembla	NSW	13.7	13.3
Brisbane	QLD	6.3	5.5
<b>Нийт</b>		<b>265.8</b>	<b>257.2</b>

Эх сурвалж: [https://en.wikipedia.org/wiki/Coal\\_in\\_Australia](https://en.wikipedia.org/wiki/Coal_in_Australia)

Reuters агентлагт мэдээлснээр Австрали нь Хятадын хоёр дахь том нүүрс нийлүүлэгч байсан хэдий ч 2020 онд хоёр Улсын хооронд дипломат харилцаа муудсантай холбоотойгоор<sup>44</sup> БНХАУ-ын зүгээс Австралиас оруулж ирэх нүүрсний импортод албан бус хориг тавьсан. БНХАУ руу экспортолдог Австралийн нүүрсний хэмжээ 2019 онд тус Улсын нүүрсний нийт экспортын дөрөвний нэгийг эзэлж байсан бол 2021, 2022 онд бараг 0 болтлоо буурсан байна. Харин 2023 оны 1 дүгээр сард “Хятадын эрчим хүчний хөрөнгө оруулалтын корпорац” Австралиас нүүрс импортлох захиалга өгсөн нь дээрх 2020 оны албан бус хориг зөөлрүүлснээс хойших анхны хэлэлцээрүүдийн нэг болсон байна.<sup>45</sup>

Энэхүү Австралийн нүүрсний импортод тавьсан албан бус хоригийн хугацаанд БНХАУ нь Монгол, Орос, Индонезоос хийх нүүрсний импортоо нэмэгдүүлсэн бөгөөд энэ нь хориг тавихаас өмнө хийгдэж байсан 80 сая тонны импортыг нөхсөн байна<sup>46</sup>

### Австралийн нүүрс экспорттой холбоотой хууль эрх зүйн орчин

Австрали Улсын нүүрсний экспорттой холбоотой зохицуулалт нь Ашигт малтмалын хууль буюу уул уурхайн тухай хуулиар зохицуулагддаг<sup>47</sup> нь ерөнхийдөө муж, орон нутаг бүрийн тус тусын хууль тогтоомжоор зохицуулагддаг боловч байгаль орчныг хамгаалах, хөдөлмөр эрхлэлт, өмчийн асуудал болон байгалийн нөөц ашигласны төлбөр зэрэг харилцаа нь Австралийн төрийн нэгдсэн хууль тогтоомжоор улс даяар нэгдмэл зохицуулагддаг.

Австралийн ашигт малтмалын буюу уул уурхайн анхны хуулиуд 1851 онд батлагдсан<sup>48</sup>. Үүнээс өмнө ашигт малтмал, газрын тос өмчлөх эрх нь нийтийн эрх зүйн хууль тогтоомжийн дагуу тухайн газар нутгийг эзэмшиж буй хүмүүст (“хөрс нь хэнийх байна, тэр нь тэнгэр болон газрын гүнийг нь эзэмшинэ” гэх эртний үзэл баримтлалын дагуу) хамаарч байсан боловч 1855 онд колони улсын парламентууд ашигт малтмалын өмчлөлийн тухай хууль гаргаснаар өмчлөлийг хаан ширээнд шилжүүлсэн

Австралийн муж, орон нутаг бүр ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тухай хууль тогтоомжоо тус тус батлан дагаж мөрддөг хэдий ч эдгээр нь агуулгын хувьд

төдийлөн зөрүүтэй биш бөгөөд үндсэн зохицуулалт нь улс даяар нэгэн жигд байдаг байна.

Өөрөөр хэлбэл, уул уурхай, ашигт малтмалын үйл ажиллагааг муж Улсын болон холбооны (“Commonwealth”) хуулиар зохицуулдаг ч тухайн муж Улсын өөрийнх нь хууль тогтоомж хамгийн чухал нөлөөтэй. Уул уурхайн тухай хууль (1971) болон Уул уурхайн дүрэм (2020) нь ашигт малтмалын үйл ажиллагааг зохицуулах гол хууль тогтоомж юм<sup>49</sup>.

Одоогийн хууль тогтоомжийн дагуу Австралийн муж, орон нутаг дах ашигт малтмалын эрх нь тухайн хэсгийн газар өмчлөгчийн биш харин харьяалах муж, орон нутгийн мэдэлд байдаг<sup>50</sup>. Ашигт малтмал нь “хаан ширээ” (“crown”)-ний нөөц гэж тооцогддог ба тухайн муж, орон нутгийн уул уурхайн хэлтсүүд хяналт тавьдаг.

Өмнөд Австралийн Уул уурхайн тухай хуулиар<sup>51</sup> болон бусад муж, Улсын хуулиар ашигт малтмал эрэх, хайх, олборлох газар нутаг, тусгай зөвшөөрлийн төрөл, түүнийг олгох, цуцлах, лиценз эзэмшигчийн эрх үүрэг, нөөц ашигласны төлбөр, нөхөн төлбөрийн харилцааг л зохицуулсан байдаг.

Австралид ашигт малтмал боловсруулах, экспортлох, борлуулахтай холбоотой хязгаарлалт маш бага байдаг ба цөөн хэдэн хязгаарлалтаас дурдвал уран болон бусад эрсдэл бүхий эрдсийн экспортод л хориг тавьдаг.

Өөрөөр хэлбэл нүүрс экспортлохтой холбоотой харилцаа нь Уул уурхайн тухай хуулиар зохицуулагддаггүй бөгөөд уурхайн үйл ажиллагаа явуулагч нь ашиглалтын лицензийн дагуу холбогдох хууль тогтоомжид заасан төлбөр төөлсний үндсэн дээр өөрийн олборлосон ашигт малтмалын өмчлөх эрхийг олж авч байгаа тул татварын тухай хууль, гаалийн тухай хууль болон чөлөөт худалдааны гэрээ (“Free Trade Agreement” or “FTA”) зэрэг холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагын дагуу экспортод чөлөөтэй гаргах эрхтэй гэж үзэхээр байна. Харин Уул уурхайн компаниуд олборлосон ашигт малтмалаа экспортлох гэж байгаа тохиолдолд эрх бүхий байгууллагаас экспорт хийх зөвшөөрөл авах шаардлагатай<sup>52</sup>.

## **Хязгаарлалт**

Австралид ашигт малтмалыг боловсруулах, экспортлох, борлуулахтай холбоотой хууль тогтоомжуудад аливаа хязгаарлалт маш бага байдаг. Цөөн хэдэн хязгаарлалтаас дурдвал:

- Ашигт малтмалын эрх эзэмшигч нь 18 насанд хүрсэн иргэн эсвэл хүчин төгөлдөр байгуулагдсан хуулийн этгээд байх ёстой;
- Цөмийн зэвсгийн эсрэг олон Улсын гэрээнд гарын үсэг зурсан орны хувьд Австрали улс конвенцын гишүүн орнуудад “уран”-ы борлуулалт хийх нь хязгаарлагдмал бөгөөд хориотой байдаг.

## **Зохицуулалтын хүрээ**<sup>53</sup>

Австралийн ашигт малтмал олборлох үйл явцын зохицуулалтын тогтолцоог ерөнхийд нь Засгийн газрын гурван түвшинд хуваадаг. Үүнд: Австралийн Холбооны

Засгийн газар, Муж Улсын засаг захиргаа, Орон нутгийн засаг захиргаа. Эдгээрээс Австралийн Холбооны Засгийн газар нь худалдаа, экспортын үйл явцыг зохицуулдаг.

Хүснэгт 15. Австрали улсын Ашигт малтмал олборлох үйл явцын зохицуулалтын тогтолцоог хүснэгтэд харуулав

Австралийн Холбооны Засгийн газар	Муж Улсын засаг захиргаа	Орон нутгийн засаг захиргаа
Бодлогын шууд бус оролцоо: татвар; гадаадын хөрөнгө оруулалт өрсөлдөөний бодлого; худалдаа, экспорт; байгаль орчин хамгаалал.	Муж улсын удирдлага; ашигт малтмалын хайгуул, ашиглалтын эрх олгох; уурхайн үйл ажиллагааг зохицуулах (байгаль орчин, хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг оролцуулан); ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр хураах.	Хот, суурин эсвэл дүүрэг/дүүргийн түвшинд үйл ажиллагаа явуулдаг орон нутгийн засаг захиргаа нь иргэдийн хэрэгцээг хангах үүрэгтэй. Орон нутгийн засаг захиргаатай харилцах нь ихэвчлэн уурхайн ажилтнууд болон тэдний гэр бүлийнхэнд зориулсан зам засвар, хотын үйлчилгээтэй холбоотой байдаг

Эх сурвалж: Судалгааны ажил

Төлбөр хураамж<sup>54</sup>

Роялти буюу нөөц ашигласны төлбөр

Ашигт малтмалын нөөц ашигласнаас төлөх төлбөр нь тухайн газар нутаг, ашигт малтмалаас хамааран өөр өөр хэмжээ, тооцоололтой байдаг. Муж, орон нутгийн засаг захиргаа нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг хураан авдаг.

Хураамжийн хувь хэмжээ нь харилцан адилгүй бөгөөд муж/нутаг дэвсгэр бүрийн хооронд мэдэгдэхүйц ялгаа байдаг. Тухайлбал үнийг тогтоохдоо “*тогтмол хувь хэмжээ*” (өөрөөр хэлбэл нэг тонны өртөг) эсвэл “*адвалорем*” (олж авсан ашигт малтмалын үнэ цэний хувь) зэрэг ялгаатай аргуудад суурилдаг.

Австралид ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн бодлого ерөнхийдөө тогтвортой байдаг хэдий ч 2022 оны 6-р сард Квинсландын засгийн газар нүүрсний нөөц ашигласны төлбөрийн горимд томоохон өөрчлөлт оруулж, тонн тутамд 150 австрали доллароос дээш үнээр нүүрсний нөөц ашигласны төлбөрийн шинэ хувь хэмжээг бий болгосноо зарласан. Энэхүү өөрчлөлт нь нүүрсний салбарын ирээдүйн хөрөнгө оруулалтыг улам хүндрүүлж, эцсийн дүндээ Квинсленд муж болон тус салбарт сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай гэж олон Улсын судлаачид дүгнэсэн байна.

2022 оны санхүүгийн жилд Австрали 413 тэрбум доллароор экспортын орлогын шинэ дээд амжилт тогтоосон бөгөөд үүний 112.8 тэрбум долларыг нүүрсний экспорт эзэлсэн байна.

## ОХУ-ын нүүрсний салбарын эрх зүйн зохицуулалт

Монгол Улс нүүрсээ БНХАУ-руу газраар тээвэрлэн экспортолдог орон бөгөөд тус улс руу газрын тээврээр тээвэрлэдэг улс бол Оросын Холбооны Улс тул тус улсын эрх зүйн орчныг судаллаа.

ОХУ нь жилд 440 сая тонн нүүрс олборлож байна. Экспортын хэмжээ нь олборлолтынхоо 50 хувийг (220 сая тонн) эзэлж байна. Нүүрсний салбар нь ОХУ-ын эдийн засгийн хөгжилд чухал үүрэг<sup>55</sup> гүйцэтгэдэг. ОХУ-ын нүүрсний гол бүс нутаг Кузбасс нь нүүрсний бүтээгдэхүүний 60 хувийг үйлдвэрлэдэг.

Одоогийн байдлаар ОХУ нь нүүрсний экспортын хэмжээгээр Индонез, Австралийн дараа дэлхийд гуравт ордог.

2022 оны 8-р сард Оросоос БНХАУ-д нийлүүлсэн нүүрсний хэмжээ сүүлийн таван жилийн хамгийн дээд хэмжээнд хүрсэн буюу 1.4 тэрбум ам.долларт хүрч, 8.5 сая тонн, мөнгөн дүнгээр тооцвол 2021 оноос хоёр дахин нэмэгджээ. 2022 оны наймдугаар сард тухайн улсад хийсэн нүүрсний экспорт 2021 оны наймдугаар сартай харьцуулахад 64 хувь, 2022 оны далдугаар сартай харьцуулахад 15 хувиар өссөн байна. Наймдугаар сард нийлүүлсэн 7.8 сая гаруй тонныг чулуун нүүрс, шахмал түлш, 0.7 сая тонныг хүрэн нүүрс эзэлж байна<sup>56</sup>.

2022 оны эхний найман сард ОХУ нь БНХАУ руу 12.3 сая тонн коксжих нүүрс экспортолсон нь энэ түүхий эдийг нийлүүлдэг хоёр дахь том нийлүүлэгч болсон. (32%). Монгол Улс энэ төрлийн нүүрснээс бараг 1 сая тонн илүү буюу 13.1 сая тонн нийлүүлсэн байна. Канад, АНУ нь Хятадад коксжих нүүрсний томоохон экспортлогч орон боловч тэдний эзлэх хувь 5.5 сая тонн ба 3.7 сая тонн (9.5%) байна.

ОХУ-ын нүүрсний ангилал нь бусад орнуудаас ялгаатай. Нүүрсийг генетик болон технологийн параметрээр ангилдаг байна. Хүснэгт 16-д ОХУ-ын нүүрсний ерөнхий ангиллыг харуулав. Дэлгэрэнгүй ангилалд нүүрсний бусад төрлүүд, дэд ангиллууд хэсэгт хэсэг тус бүрийг нарийн ангилдаг. Тухайлбал “Б” үсгэн тэмдэглэгээтэй хүрэн нүүрсний төрөл нь 1Б,2Б,3Б хэсгүүдэд хуваагддаг. Мөн “Д” тэмдэгтэй урт дөлт нүүрс болон “Г” тэмдэглэгээтэй хийжсэн нүүрстэй нийлж “ДГ” тэмдэглэгээтэй урт дөлт хийжсэн нүүрс гэх мэтээр нарийвчлан ангилдаг.

Хүснэгт 16. ОХУ-ын нүүрсний ерөнхий ангилал<sup>57</sup>

Нүүрсний төрөл	Үсгэн тэмдэглэгээ	Дэгдэмхий бодисын гарц V,%	Нүүрстөрөгчийн агууламж C, %	Шаталтын дулаан Q,ккал/кг
Хүрэн	Б	41 и более	<76	6900-7500
Урт дөлт	Д	>39	76	7500-8000
Хийжсэн	Г	36	83	7900-8600
Тослог		30	86	8300-8700
Коксждог	К	20	88	8400-8700
Гачигданги бөстдөг	ОС	15	89	8450-8780

Гачигданги	T	12	90	7300-8750
Антрацит	A	8-ааас багагүй	>91	8100-8750

Эх сурвалж: [www.ru.wikipedia.org](http://www.ru.wikipedia.org)

Нүүрс тээвэрлэх гол тээврийн хэрэгсэл бол төмөр зам юм. Анхдагч эрчим хүчний тээвэрлэгчдийн 30 хүртэлх хувийг төмөр замаар тээвэрлэдэг бөгөөд тээвэрлэлт хийдэг хамгийн том төмөр замын компани бол Оросын төмөр зам ХК (РЖД) бөгөөд ялангуяа нүүрсний салбарын хувьд Баруун Сибирийн салбар гол нь юм.

### **ОХУ-ын Нүүрсний экспортын хууль эрх зүйн орчин**

Одоогийн байдлаар ОХУ-ын Эрчим хүчний яам нь нүүрсний салбарын эрх зүйн орчныг зохицуулдаг. Тиймээс ОХУ-д нүүрсний салбарын эрх зүй нь холбогдох яамдын дүрэм журмаар зохицуулагдаж байна.

ОХУ-ын нүүрсний салбарын эрх зүйн зохицуулалтын үндсийг тодорхойлсон хууль нь ОХУ-ын Үндсэн хууль, уул уурхайн үйл ажиллагааг Газрын хэвлийн тухай хуулиар, хилээр бүтээгдэхүүн, түүхий эд, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхтэй холбоотой, гаалийн бүрдүүлэлт, тариф тогтоох, гаалийн тусгай журам, гаалийн төлбөр, гаалийн хяналт зэргийг ОХУ-ын Гаалийн хуулиар, газрын газрын хэвлийг ашиглах эрхийн тусгай зөвшөөрлийн үндсэн дээр ашигт малтмал олборлогчид татварыг Татварын хуульд заасны төлбөр төлөх зэргээр нүүрсний экспортын эрх зүй зохицуулагдаж байна. Жич: татварын хувь хэмжээг тогтоохдоо: ОХУ-ын татварын хуулийн 26 дугаар бүлэгт татварын хувь дараах байдлаар татварын хэмжээг тогтоосон байна.

- Олборлосон ашигт малтмалын үнэ цэнийг тодорхойлсон татвар дээр адвалорын хувь хэмжээг хэрэглэнэ.

- Олборлосон ашигт малтмалын хэмжээгээр тодорхойлогддог татвар дээр тодорхой хувь хэмжээ(тонн тутамд рубль) , 0 хувийн татварын хувь хэмжээ (0 рубль) гэх мэт ялгаатай аргуудаар тогтоодог.

Тооцоолол:

1. Олборлосон ашигт малтмалын өртөг=олборлосон ашигт малтмалын тоо хэмжээ\*олборлосон ашигт малтмалын тоо хэмжээ
2. Олборлосон ашигт малтмалын нэгжийн өртөг=олборлосон ашигт малтмалын борлуулалтын орлого:олборлосон ашигт малтмалын тоо хэмжээ Эсвэл олборлосон ашигт малтмалын нэгжийн өртөг=ашигт малтмалын тооцоолсон үнэ:олборлосон ашигт малтмалын тоо хэмжээ
3. Ашигт малтмалын борлуулалтаас олсон орлого=НӨАТ, Онцгой албан татварын үнэ-татвар төлөгчийн ашигт малтмал хүргэх зардлын хэмжээ

Мөн ОХУ Нүүрсний аж үйлдвэрийг 2035 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр боловсруулан баталсан нь нүүрсний салбарт баримтлах төрийн бодлого юм. Хөтөлбөрийн эрх зүйн үндэс нь ОХУ-ын Үндсэн хууль, холбооны үндсэн хууль, холбооны хууль тогтоомж, түүнчлэн ОХУ-ын Ерөнхийлөгч, ОХУ-ын Засгийн газрын эрх зүйн актууд юм. Тус салбарын нүүрсний олборлолтыг нэмэгдүүлэх чадвар, нүүрсний

бүтээгдэхүүний борлуулалтын ашиг орлого, экспортын дэд бүтцийн хязгаарлалтыг харгалзан ОХУ-ын нүүрсний гадаад, дотоодын зах зээлд эрэлт хэрэгцээг тодорхойлохыг тусгасан. Хөтөлбөрийн дагуу хамгийн аюулгүй уул уурхай, геологийн нөхцөлд олборлолт явуулах боломжтой нүүрсний ордуудын газрын хэвлийд тусгай зөвшөөрөл олгох, үр ашиг багатай үйлдвэрлэлийн байгууламжуудыг үе шаттайгаар татан буулгах, шинэлэг технологи нэвтрүүлэх, нүүрс олборлох, боловсруулах, тээвэрлэх үйл явцыг автоматжуулах, роботжуулах, мөн нүүрсний чанарыг сайжруулах, нүүрсний үйлдвэрлэлийг өргөжүүлэхээр төлөвлөсөн байна.



## ДУГНЭЛТ

Энэхүү судалгааны ажлын хүрээнд нүүрсний экспортын эрх зүйн орчныг боловсронгуй болгоход анхаарах асуудлын талаар авч үзсэн боловч эдгээр асуудлууд нь эрдэс баялгийн бүтээгдэхүүний экспортод нийтлэг хамааралтай буюу зөвхөн нүүрсний экспортоор хязгаарлагдахааргүй байна. Монгол Улс Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орох болохын хувьд уг байгууллагаас баталсан тарифын болон тарифын бус зохицуулалтад хамаарах дүрмийг баримталдаг. Мөн Монгол Улсын Үндсэн хуулиар өрсөлдөөнд суурилсан зах зээлийн эдийн засгийн чиг баримжаатай байхыг 30 жилийн өмнө тодорхойлсон. Иймд зах зээл дэх төрийн оролцоог боломжит хэмжээнд бууруулах нь нүүрсний болон бусад түүхий эдийн экспортод ч хамааралтай юм.

Иймд төрөөс “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай” хууль гаргаж мөрдөхөөр болж байгаа дэвшилттэй тал юм. Цаашид энэхүү биржийн тухай хууль нь зөвхөн санхүүгийн хэрэгслээр дамжуулж бараа, түүхий эдийг зохицуулалттай зах зээлээр дамжуулан арилжаа явуулж, тухайн гэрээний тодорхойлолтод заагдсан бараа түүхий эдийн худалдах-худалдан авах үнэ болон хаанаас хаашаа ямар хэмжээтэйгээр нийлүүлэлт хийгдэх асуудлыг л зохицуулах боломжтой байна. Үүний дараагийн шат буюу тухайн бараа түүхий эдийн логистикийн асуудлыг хэрхэн ямар субъект хэрхэн тээвэрлэж экспортлох асуудал өнөөдөр ч бүрэн зохицуулагдаагүй, үүний улмаас төр шууд хөндлөнгөөс бизнесийн харилцаанд оролцох боломж нээлттэй, ийм бодлого баримталж байгаа нь уг хуулийг бодитой хэрэгжих нөхцөлд саад болох хүчин зүйлсийн нэг юм.

Монгол Улс Олон Улсын гаалийн байгууллагын гишүүний хувьд экспортын тээврийг олон улсын тээвэр зуучлалын эрх бүхий субъектүүд гүйцэтгэх, эдгээр нь ямар хэлбэрээр худалдан авагчийн бараа бүтээгдэхүүнийг хаанаас хаашаа хүргэж өгөхийг тодорхойлох боломжтой эрх зүйн зохицуулалт байгаа боловч хэрхэн яаж, хэн хийх нь буюу процессын талаар тусгасан зохицуулалтууд байхгүй байна. Салбар хоорондын зохицуулалтууд нэгдсэн ойлголт, хэрэгжүүлэх механизм байхгүй нь эрх зүйн орчин хангалтгүй байгааг харуулж байна. Үүнээс хамааран нүүрсний экспортоос олох боломжит ашгаа Монгол Улс алдсаар байна.

Монгол Улсын Гаалийн тухай хуульд экспорт, импортын бараа бүтээгдэхүүнд БТКУС-н код олгох ажлыг Гаалийн байгууллага хийдэг, эрдэс баялгийн тэр дундаа нүүрсийг экспортлоход чанар стандартаас хамаарч олон төрлийн нүүрсийг олборлож байгаа бөгөөд БТКУС-ийн кодоос хамаарч цөөхөн нэр төрлөөр олон төрлийн нүүрсийг экспортод олон үнээр гаргаж байгаа нь хамгийн буруу жишиг болоод байна.

Зохицуулалттай зах зээл буюу тодорхой дүрэм журмаар зохицуулагдсан санхүү, бизнесийн харилцааны хүрээнд явагдах арилжаа нь тодорхой стандартчилагдсан санхүүгийн гэрээг авах/ зарах захиалгаас хамааралтай эрэлт/нийлүүлэлтээр үнэ тогтох процессыг дэмжих юм. Энэхүү арилжааны процесс нь гэрээ хаагдах өдрийг хүртэл үнэ байнга өөрчлөгдөх бололцоотой тул нүүрс худалдах-худалдан авах хэрэгцээ тодорхой шалтгаанаар өсөж, буурах зэргээр өөрчлөгдөж буй үед ч үнийн тэнцвэр бий болгох ач холбогдолтой. Тухайлбал, үнэ ханшийн зөрүүнээс ашиг олох сонирхол бүхий хувь хүн, хуулийн этгээдүүд мэргэжлийн зуучлагчаар дамжуулан уг арилжаанд оролцсоноор тухайн гэрээ хаагдах хүртэл олон оролцогчдын өгөх үнийн саналаар тэнцвэрт үнэ

тогтоох боломжтой болдог нь эрдэс баялаг, түүний дотор нүүрсний экспорт нэг улсаас хамааралтай манай улсын хувьд тухайлан анхаарч хөгжүүлэх шаардлагатай салбар болно.

Биржийн үндсэн үйл ажиллагаа нь оролцогчдоос ирүүлсэн захиалгыг бүртгэх, улмаар тулгалт хийж хэлцэл бүртгэх ба хэлцлийн үр дүнд тогтсон үнэ, зах зээлийн бусад мэдээллийг нийтэд мэдээлэх байдаг. Хэлцлийн үнийг олон улсад хэд хэдэн аргыг хэрэглэдэг бөгөөд фьючерс гэрээний хувьд тэнцвэрт үнийн арга буюу дуудлага худалдааны зарчмаар, эсвэл үргэлжилсэн арилжаагаар тогтоож байна. Уул уурхайн гаралтай бүтээгдэхүүнийг арилжих биржийн хувьд дээрх аргуудыг дангаар болон хослуулан ашиглах боломжтой гэж үзэж байна.

Өнөөдөр дэлхийн таваарын биржүүд дээрх аргачлалаар үнэ тогтоож эрдэс түүхий эдийн үнийг тогтоосноор уул уурхайн олборлох салбарын компаниуд энэхүү тогтсон үнээр бараа бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээг худалдан авагчидтай хийдэг болсон.

Монгол Улсын Засгийн газар БНХАУ-н Засгийн газар хоорондын Гаалийн асуудлаар хамтран ажиллах хэлэлцээрээр хил гаалиар нэвтрэх тээврийн хэрэгслийн зохицуулалтыг 2 тал хамтран хийж болох ерөнхий зохицуулалт байгаа нь энэхүү харилцааг цаашид нарийвчлан тодорхой болгох боломж байгааг харуулж байна

## НОМ ЗҮЙ

- П.Очирбат. (1999). Монгол улсын эрдэс баялгийн цогцолборуудын хөгжлийн стратеги.
- С.Цэдэндорж. (2000 ). Нүүрсний ил уурхайн уулын ажлын төлөвлөлт, горимын болон параметрийн оновчлол.
- Л.Дамдинсүрэн. (2008). Уул уурхайн үйлдвэрийн удирдлагын арга барилыг төгөлдөржүүлэх зарим асуудлууд.
- З.Сундуй. (2010). Нүүрсний аж үйлдвэрийн хөгжлийн инновацийн стратеги.
- Ц.Батдорж, Г. Ц. (2012). Нүүрсний ангилал, экспорт ба зах зээлийн үнэ, татварын хувь хэмжээний талаарх зарим орны туршлага. УИХ-ын тамгын газрын дэргэдэх судалгааны төв.
- Н. Түвшинтөгс, Ц. Б. (2009). Нүүрсний зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, Монгол улсын нүүрсний экспортыг нэмэгдүүлэх боломж, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн талаарх судалгаа- мэдээлэл . УИХ-ын Тамгын газар, Судалгаа, Шинжилгээ, онол нийтгэй харилцах төв.
- Ж.Чимгээ, А. (2020). Уул уурхайн гаралтай экспортын бүтээгдэхүүний борлуулалтын үнэд нөлөөлөх хүчин зүйлийн судалгаа.
- Ц.Норовдондог, Ш. Б. (2021 ). "Экспортыг дэмжих гадаад худалдааны бодлого, эрх зүйн орчин, бусад орнуудын туршлага. Улаанбаатар.
- Монголын Эрдэс баялгийн биржийн төслийн баг. (2020). Эрдэс баялгийн бирж байгуулах ТЭЗҮ. Улаанбаатар.
- Монголын экспортлогчдын холбоо. (2013). Монгол улсад уул уурхайн бирж байгуулах боломж судалгааны ажлын тайлан.
- Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн үзэл баримтлал. (2021). Монгол Улсын Их Хурал цахим хэлэлцүүлэг : <https://forum.parliament.mn/>-ээс Гаргасан
- хороо, Ү. с. (2019). Аж үйлдвэрийн салбар-2018. Улаанбаатар.
- world bank. (2023 оны 02 14). the world bank . <https://www.worldbank.org/en/home:https://documents.worldbank.org/en/publication/documents-reports/documentdetail/158851537431181525/investment-reform-map-for-mongolia-a-foundation-for-a-new-investment-policy-and-promotion-strategy-ээс> Гаргасан

## ЦАХИМ ЭХ СУРВАЛЖУУД

- 
- 1 (world bank, 2023)
  - 2 (Аж үйлдвэрийн салбар, 2018)
  - 3 (Гадаад худалдаа, 2018)
  - 4 (Нүүрсний зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, МУ-ын нүүрсний экспортыг нэмэгдүүлэх боломж, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн талаархи судалгаа- мэдээлэл, 2009)
  - 5 (Нүүрсний ангилал, экспорт ба зах зээлийн үнэ, татварын хувь хэмжээний талаарх зарим орны туршлага, 2012)
  - 6 (Монгол Улсад уул уурхайн бирж байгуулах боломж, 2013)
  - 7 (Монголын уул уурхайн салбарын Авлигын эрсдлийн үнэлгээ , 2016)
  - 8 (Уул уурхайн гаралтай экспортын бүтээгдэхүүний борлуулалтын үнэд нөлөөлөх хүчин зүйлийн судалгаа, 2020)
  - 9 (Эрдэс баялгийн бирж байгуулах төсөл ТЭЗҮ, 2020)
  - 10 (баг, Эрдэс баялгийн бирж байгуулах төсөл ТЭЗҮ, 2020)
  - 11 (Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн эрх зүйн зохицуулалтыг бий болгох нь, 2022)
  - 12 (www.1212.mn, 2023)
  - 13 (mmhi.gov.mn, 2023)
  - 14 (mmhi.gov.mn, 2023)
  - 15 (worldstopexports.com, 2023)
  - 16 (mrtd.gov.mn, 2023)
  - 17 (mongolianminingjournal.com, 2023)
  - 18 (яам У. у., mmhi.gov.mn, 2023)
  - 19 (legalinfo.mn, 2023)
  - 20 (legalinfo.mn, 2023)
  - 21 (legalinfo.mn, 2023)
  - 22 (legalinfo.mn, 2023)
  - 23 (legalinfo.mn, 2023)
  - 24 (legalinfo.mn, 2023)
  - 25 (legalinfo.mn, 2023)
  - 26 (mongolia.gov.mn, 2023)
  - 27 (legalinfo.mn, 2023)
  - 28 (legalinfo.mn, 2023)
  - 29 (legalinfo.mn, 2023)
  - 30 (Gibbons, 2023)
  - 31 (Gibbons, www.industry.gov.au.com, 2023)
  - 32 (baidu.com, 2022)
  - 33 (www.1clicktong.com, 2019))
  - 34 (www.gov.cn, 2023)
  - 35 (mee.gov.cn, 2023)
  - 36 (www.law.pkulaw.com, 2023)
  - 37 (www.nea.gov.cn, 2023)
  - 38 (www.ccpitzj.go.cn, 2023)
  - 39 (Michelle Cunningham, 2023)
  - 40 (Australia, 2023)
  - 41 (Paul, 2023)
  - 42 (Australia, www.ga.gov.au, 2023)
  - 43 (www.ga.gov.au.com, 2023)

---

<sup>44</sup> сүүлээр Канберра болон Бээжингийн хооронд коронавирусын гарал үүслийг шалгахтай холбоотой асуудлаар маргаан үүссэнтэй холбоотойгоор албан бус хориг тавьсан гэж Bloomberg News мэдээлсэн байна. (News, 2023)

<sup>45</sup> (www.reuters.com, 2023)

<sup>46</sup> (www.thediplomat.com , 2023)

<sup>47</sup> (goverment, 2023)

<sup>48</sup> (www.lawhandbook.sa.gov.au, 2023).

<sup>49</sup> (www.lawhandbook.sa.gov.au, 2023)

<sup>50</sup> (McKenzie, 2023)

<sup>51</sup> (www.dmp.wa.gov.au, 2023)

<sup>52</sup> (Mining, www.lawhandbook.sa.gov.au, 2023)

<sup>53</sup> (Aylin Cunsolo, 2023)

<sup>54</sup> (Aylin Cunsolo, www.thomsonreuters.com, 2023)

<sup>55</sup> (www.concil.gov.ru, 2023)

<sup>56</sup> (www.expert.ru.com, 2023)

<sup>57</sup> (wikipedia, 2023)